МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ УЛС, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИТ, ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

Мэдээлэл лавлагаа
Судалгааны код: СТ-24/412

Захиалагч:	Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг
Хянасан:	ПСХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт
Судалгааг удирдсан:	ПСХХ-ийн Судалгааны хэлтсийн дарга П.Түмэнцэцэг
Судлаачид:	Г.Билгээ, Э.Дашзэгвэ, Ц.Ариунаа, Э.Билгүүн, П.Уранчимэг

УЛААНБААТАР
2024 ОН

АГУУЛГА

УДИРТГАЛ 2

Нэг. ТӨРИЙН ЗОРИЛТ ЧИГ ҮҮРГИЙГ ХУВИЙН ХЭВШЛЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТУХАЙ **3**

1.1.Төрийн чиг үүрэг ба төр, хувийн хэвшлийн түншлэл 3

1.2.Төрийн зарим зорилт, чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хэрэгцээ, шаардлага 3

1.3.Төрийн зарим зорилт, чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хэрэгцээ, шаардлага 4

1.4.Төрийн зарим зорилт, чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх санхүүжилтийн хэлбэр 5

1.5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн давуу талууд 5

1.6.Төр зарим зорилт, чиг үүргээ хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхийн сул талууд 6

1.7.Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт 7

1.8.Монгол Улсад тулгарч буй бэрхшээлүүд 9

Хоёр. ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД ХУВИЙН ХЭВШИЛТЭЙ ӨРСӨЛДӨХГҮЙ БАЙХ ЗАРЧМЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ **11**

2.1.Австрали Улс 12

2.2.Филиппин Улс 16

2.3.Финланд Улс 18

Гурав. ТӨРИЙН ТОДОРХОЙ ЧИГ ҮҮРЭГ, ЭРХИЙГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТОЙМ **22**

Дөрөв. ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ **24**

Тав. ХАВСРАЛТУУД **26**

5.1.Төрийн тодорхой чиг үүргийг бусад байгууллагаар гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан зарим хууль тогтоомж 26

5.2.Төрийн байгууллага, албан тушаалтны зарим эрхийг бусдад шилжүүлэх буюу олгохтой холбоотой харилцааг зохицуулсан зарим хууль тогтоомж 38

5.3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн байгуулагдсан талаарх мэдээлэл лавлагаа 40

5.4.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт (сая төгрөгөөр) 47

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ 50

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн ирүүлсэн захиалгын дагуу “Монгол Улс, гадаадын зарим орны төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн зохицуулалт, Монгол Улсын төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээлэл лавлагаа”-г Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

- Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхэд хууль, эрх зүйн хүрээнд тулгарч буй асуудал, өнөөдрийн эрх зүйн орчны хүрээнд хувийн хэвшилд төрийн ажлыг шилжүүлснээр давуу болон сул, сөрөг тал;
- Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар төрийн эрхлэх тодорхой ажлыг бусад байгууллагаар гүйцэтгүүлэх, эрх шилжүүлэх, хуулиар тусгайлан эрх олгосон заалт, түүнтэй уялдан гарсан Засгийн газрын тогтоол, бусад шийдвэрийн жагсаалт;
- төрийн өмчит (төрийн өмчийн оролцоотой) хуулийн этгээд хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг тодорхойлсон гадаад улсын хууль эрх зүйн орчин;
- Монгол Улсын төрийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгж байгууллагын жагсаалт, тэдгээрийн эрх зүйн зохицуулалт зэрэг асуудлаар мэдээлэл лавлагаа бэлтгэх.

Судалгааны хамрах хүрээ: Энэхүү мэдээлэл лавлагаа нь нэгд, төр, хувийн хэвшлийн түншлэл, давуу ба сул тал, Монгол Улсын эрх зүйн орчин ба тулгарч буй бэрхшээлийн талаар, хоёрт, төрийн өмчит (төрийн өмчийн оролцоотой) хуулийн этгээд хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчим бүхий Австрали, Филиппин, Финланд зэрэг улсын эрх зүйн зохицуулалтын талаар, гуравт, төрийн тодорхой чиг үүрэг, эрхийг бусдад шилжүүлэх талаарх Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын талаар, эцэст нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаарх мэдээлэл лавлагааг бэлтгэх

Судалгааны бүтэц: Мэдээлэл лавлагаанд *Нэгдүгээрт*, төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар, *хоёрдугаарт*, төрийн өмчит (төрийн өмчийн оролцоотой) хуулийн этгээд хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх буюу өрсөлдөөнд төвийг сахих зарчмын талаарх Австрали, Филиппин, Финланд улсуудын эрх зүйн зохицуулалтын талаар, *гуравдугаарт*, төрийн тодорхой чиг үүрэг, эрхийг бусдад шилжүүлэх талаарх Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын талаар, *дөрөвдүгээрт*, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар судалсан болно.

Хавсралтад төрийн тодорхой чиг үүргийг бусад байгууллагаар гүйцэтгүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтны зарим эрхийг бусдад шилжүүлэх буюу олгохтой холбоотой нийтлэг болон харилцааг зохицуулсан зарим хууль тогтоомжийн жагсаалтыг багтаасан болно.

Түлхүүр үг: төрийн өмчит хуулийн этгээд, хувийн хэвшил, нийтийн эрх зүйн этгээд, нийтийн эрх зүйн хуулийн этгээд.

Key words: state-owned enterprise, private sector, public legal entity, principle of competitive neutrality, non-competitive.

Нэг. ТӨРИЙН ЗОРИЛТ ЧИГ ҮҮРГИЙГ ХУВИЙН ХЭВШЛЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТУХАЙ

1.1.Төрийн чиг үүрэг ба төр, хувийн хэвшлийн түншлэл

Хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд нийгмийн удирдлагыг хэрэгжүүлэгч үндсэн зохион байгуулалтын бүтэц – төр онцгой байр суурь, чиг үүрэгтэй байсаар ирсэн. Нийгмийн хөгжил, хувьслын үе шатны тусгал болсон төрийн агуулга, хэлбэр, чиг үүрэг ч мөнхүү хөгжлийн чиг хандлагыг даган хувьсан өөрчлөгдөж иржээ. Үүний нэг жишээ бол Дэлхийн II дайны дараах дэлхийн эдийн засгийн огцом тэлэлт, түүний дараах 1960-аад оны эдийн засгийн хямрал, залгуулаад төсөв, санхүүгийн нөөцийн гүн дутагдалд орсон 1970-аад оны үед хөгжингүй улс орнуудын төрийн удирдлагад шинээр гарч ирсэн чиг хандлага болох Улсын салбарын шинэ удирдлага (New Public Management, NPM) юм. [1] Энэхүү хандлага нь төрийн захиргааны уламжлалт тогтолцооны үр ашиггүй, хариу үйлдэл үзүүлэх чадвар дутмаг, иргэдийн буюу хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн байдлыг харгалзан үздэггүй зэрэг алдаа, дутагдлыг засаж залруулах зорилготой байсан. Улсын салбарын шинэ удирдлагад хувийн хэвшлийн удирдлагын практикт хэрэглэгддэг, зах зээлийн механизм, гүйцэтгэлд суурилсан удирдлагын арга барилыг төрийн захиргааны салбарт нэвтрүүлэхийг зорьсон байна. Тухайн үзэл хандлагыг амьдралд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх үйл явцад Засгийн газрын үйл ажиллагааны хүрээнд маш олон арга хэрэгсэл шинээр туршигдан ашиглагдаж байсан.

Эдгээрээс хамгийн үр дүнтэй төрийн захиргааны арга хэрэгслийн нэг нь ***төр, хувийн хэвшлийн түншлэл*** юм.[2] Засгийн газрын зүгээс өөрийн гүйцэтгэдэг зарим чиг үүрэг, эсхүл өөрийн эрх мэдлийн нэг хэсгийг тодорхой хугацаанд хувийн хэвшилд шилжүүлэх, хувийн хэвшилтэй бизнесийн зарчимд тулгуурласан хамтын ажиллагааг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх нь тухайн үедээ цоо шинэ үзэгдэл байжээ.

1.2.Төрийн зарим зорилт, чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хэрэгцээ, шаардлага

Улс орнуудын Засгийн газрын зүгээс дараах хэд хэдэн шалтгааны улмаас өөрийн чиг үүргийг хэвшилд шилжүүлэх шаардлага үүсдэг байна:

- үйл ажиллагаагаа илүү оновчтой, үр дүнтэй болгох;
- төрийн захиргааны төвлөрлийг сааруулах;
- улсын төсвийн ачааллыг бууруулах;
- улсын салбарын үйл ажиллагаанд хувийн хэвшлийг татан оролцуулах;
- дэд бүтцийн болон нийгмийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах;
- хувийн хэвшилд ашиглагдаж байгаа хүний, техник, технологийн нөөцийг нийтийн эрх ашгийн төлөө ашиглах зэрэг юм.

[1] Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл: үзэл баримтлал, хэрэгжилт. Ш.Батсүх. УБ. 2004.
[2] Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх онолын зарим асуудалд. Ч.Баатар. УБ. 2018.

Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлснээр төрийн үүрэг, хариуцлагыг багасгах, төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах, төрийн үйлчилгээг бага зардлаар чанартай, илүү олон хүнд хүргэх боломжийг бүрдүүлдэг.

1.3.Төрийн зарим зорилт, чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хэрэгцээ, шаардлага

Одоогоор Дэлхийн улс орнуудад төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлдэг нэлээд олон арга хэлбэр байдаг бөгөөд доор дурдсан хэлбэрүүд нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг байна[3]:

- засгийн газрын худалдан авах ажиллагаа буюу төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах (Public Procurement);
- төрийн тодорхой чиг үүрэг, нийтлэг үйлчилгээг хувийн хэвшил тухайлсан гэрээгээр гүйцэтгэх;
- төр өөрийн тодорхой чиг үүргээ өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага, мэргэжлийн холбоодоор дамжуулан гүйцэтгүүлэх;
- тухайн хэрэгцээт ажил үйлчилгээг нарийн мэргэшсэн мэргэжлийн байгууллага, хувь хүмүүсээр гүйцэтгүүлэх буюу Аутсорсинг (Outsourcing);
- төрийн зүгээс хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчидтай гэрээ байгуулсны үндсэн дээр хамтран ажиллах ажиллах (Concession Agreement) зэрэг юм.

Төр, хувийн хэвшлийн түншлэл (Public, Private, Partnership) буюу PPP, товчилсон нэрээрээ ихэвчлэн 3-Р хэмээн нэрлэгддэг энэхүү төрийн захиргааны арга, хэрэгсэл нь дээр дурдсанчлан маш олон хэлбэртэй бөгөөд улс орон бүр өөрийн төрийн бодлогын онцлог, өвөрмөц байдалдаа тулгуурлан хэрэгжүүлж байна.

Дэлхийн улс орнуудын төр, хувийн хэвшлийн түншлэлийн туршлагаас үзэхэд дараах салбаруудад ихэвчлэн PPP-г хэрэгжүүлсэн[4]:

- тээврийн (авто зам, төмөр зам, усан зам, далайн тээвэр, боомтууд,агаарын тээвэр, метро болон нийтийн тээврийн бусад төрлүүд);
- нийтийн эзэмшлийн (усан хангамж, хог хаягдал, нутаг дэвсгэрийн нийтийн байгууламж, нийгэм-ахуйн объектууд, гидротехникийн байгууламж);
- эрчим хүчний (цахилгаан болон дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх,дамжуулах, хуваарилах, дулаан, хийн ба эрчим хүчний хангамж,нийтийн гэрэлтүүлэг, бусад объектууд);
- нийгмийн (эрүүл мэнд, амралт-эрүүл ахуйн эмчилгээ сувилгаа,боловсрол, соёл, нийгмийн үйлчилгээ, спорт);
- байгаль орчны (дархан цаазтай, эсхүл тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, байгаль орчны хамгаалал, ашигт малтмалын олборлолт гэх мэт.) зэрэг юм.

[3] Мөн тэнд.
[4] Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлага. Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газар. Эдийн засгийн хөгжлийн яам. 2013 он. http://nda.gov.mn/backend/f/lZAOkdjzwF.pdf

1.4.Төрийн зарим зорилт, чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх санхүүжилтийн хэлбэр

Эдгээр салбаруудад хэрэгжиж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүдийн санхүүжилт нь хэрхэн хийгдэж байгаа байдлаар нь дараах гурван үндсэн хэлбэрт ангилдаг:

- улсын төсвийн суурьтай буюу засгийн газраас санхүүжих;
- улсын төсвийн суурь байхгүй буюу хэрэглэгч, зах зээлээс санхүүжих;
- холимог буюу төсвийн татаастай зэрэг байдаг.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай ойлголт, үг хэллэг сүүлийн үед олон нийтийн дунд ихээхэн хэрэглэгдэж, ашиглагдаж байгаа нь сайн хэрэг боловч тэр нь төр, хувийн хэвшил хамтран бизнес хийх, төр хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хутгалдан оролцох ёстой гэх мэт андуу ташаа үйлдлийн зөвтгөл, үндэслэл болох ёсгүй юм. Ер нь Public+Private=Partnership гэдэг нь төр нийтийн эрх ашгийг төлөөлөх субъектийн хувьд хувийн хэвшилд нийтийн бараа, үйлчилгээг тэдний нэрийн өмнөөс захиалан, гэрээгээр гүйцэтгүүлэх тухай ойлголт бөгөөд төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын хоорондын урт хугацааны гэрээний үндсэн дээр хийгддэг.

1.5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн давуу талууд[5]

Төр, хувийн хэвшлийн түншлэл нь нийтлэг байдлаар дараах давуу талуудтай байдаг ажээ:

Эдийн засгийн үр ашиг: Хувийн хэвшлээр төрийн зарим үүргийг гүйцэтгүүлснээр төсвийн зардлыг хэмнэх боломжтой. Хувийн хэвшил үр ашгийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын өртгийг бууруулдаг.

Асуудлыг шийдвэрлэх чадвар, хурд: Хувийн хэвшил нь илүү уян хатан, шуурхай ажилладаг тул төрийн үйл ажиллагааг хурдасгадаг. Энэ нь ялангуяа барилга, дэд бүтцийн төслүүдэд онцгой үр дүнтэй байдаг.

Эрсдэл хуваалцах: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гол давуу талын нэг нь эрсдэлийг төр, хувийн хэвшлийн хооронд хуваах явдал юм. Барилга, ашиглалт, эрэлт хэрэгцээтэй холбоотой эрсдэлийг хувийн хэвшилд шилжүүлж, төрийн ачааллыг бууруулах боломжтой.

Хувийн хэвшлийн туршлага, инновацын хүртээмж: Хувийн компаниуд ихэвчлэн дэвшилтэт технологи, төслийн менежментийн ур чадвар, шинэлэг шийдлүүдийг санал болгодог бөгөөд энэ нь төрийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээтэй харьцуулахад хамаагүй илүү чанартай дэд бүтэц, үйлчилгээг бий болгодог байна.

Нийтийн дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх: Төсвийн хүндрэлтэй тулгарсан Засгийн газруудад хувийн санхүүжилт авах боломжийг олгодог тул төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан чухал дэд бүтцийг хөгжүүлэх

[5] Мөн тэнд.

боломжийг олгодог. Энэ нь улсын төсөвт ирэх санхүүгийн ачааллыг бууруулж, олон төсөл нэгэн зэрэг эхлүүлэх боломцоог бий болгодог байна.

Мөнгөний хувьд илүү сайн үнэ цэнэ (VFM): Төр, хувийн хэвшлийн түншлэлийг ихэвчлэн төрийн үйлчилгээг илүү бага зардал, хямд үнээр хүргэхийн тулд байгуулдаг. Хувийн аж ахуйн нэгжүүд төслийн амьдралын мөчлөгийн өртгийг оновчтой болгох, эцсийн бүтээгдэхүүн нь урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангахад түлхүү анхаардаг.

Илүү чанартай үйлчилгээ: Хувийн хэвшлийн байгууллагууд зах зээлд өрсөлддөг тул чанарыг сайжруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд илүү анхаардаг. Энэ нь нийгмийн үйлчилгээний салбарт чухал ач холбогдолтой ажээ.

1.6.Төр зарим зорилт, чиг үүргээ хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхийн сул талууд[6]

Төр, хувийн хэвшлийн түншлэл нь нийтлэг байдлаар дараах сул талуудтай байдаг ажээ:

Нарийн төвөгтэй гэрээ хэлэлцээр: Боловсруулах, хэлэлцэх, батлахад ихээхэн хэмжээний цаг хугацаа, нөөц шаардлагатай нарийн төвөгтэй гэрээнүүд хийгддэг. Хамтын ажиллагааны нөхцөл, түүний дотор эрсдэлийн хуваарилалт, хариуцлагын талаар тохиролцох нь цаг хугацаа их шаарддаг бөгөөд төслийн хэрэгжилтийг удаашруулж болзошгүй байдаг.

Өндөр зардал гарах боломж: Хувийн хэвшлийнхэн илүү үр ашигтай байхыг эрмэлздэг ч төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүд нь санхүүжилтийн өндөр зардал, хувийн хөрөнгө оруулагчдад ашиг олох хэрэгцээ шаардлага зэргээс улбаалан урт хугацаандаа илүү их өндөр зардалтай байх явдал байдаг бөгөөд зардлыг өндөр төлбөр, үйлчилгээний хураамжаар дамжуулан хэрэглэгчдэд шилжүүлэх явдал гардаг.

Эрсдэл хувийн хэвшилд хэт шилжих эрсдэл: Гэрээний дагуу эрсдэл ихэвчлэн хувийн хэвшилд шилждэг. Гэвч, энэ нь зарим тохиолдолд хувийн хэвшилд хэт их дарамт үүсгэж, төслийн хэрэгжилт удаашрах, зогсонги байдалд хүргэх эрсдэл бий болгодог. Хувийн хэвшлийн байгууллагууд тодорхой хэмжээний ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг тул нийгмийн хэрэгцээнд нийцэхгүй байж болох магадлалтай. Хэрэв хувийн түнш хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй бол төрийн сектор оролцох шаардлагатай болж, зардал нэмэгдэж, тасалдал үүсэж болзошгүй. Хувийн компаниуд ч санхүүгийн хүндрэлтэй тулгарч, үйлчилгээний тасралтгүй байдал, чанарт нөлөөлж болзошгүй юм.

Уян хатан чанар дутмаг: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ нь ихэвчлэн хэдэн арван жилээр үргэлжилдэг бөгөөд дахин хэлэлцээ хийхэд хүндрэлтэй байдаг төдийгүй, эсхүл асар их зардалтай байдаг. Хэрэв засгийн газрын тэргүүлэх чиглэл болон олон нийтийн хэрэгцээ цаг хугацааны явцад өөрчлөгдвөл түншлэлийг шинэ нөхцөл байдалд дасан зохицуулахад илүү их бэрхшээлтэй байж болно.

[6] Мөн тэнд.

Олон нийтийн эсэргүүцэл: Зарим төрийн чиг үүрэг нь нийгмийн ач холбогдол өндөртэй байдаг, тэдгээр нь хэт арилжааны агуулгатай байх нь иргэдийн дунд эсэргүүцэл төрүүлэх шалтгаан болдог. Тухайлбал, Эрүүл мэнд, боловсрол, нийтийн аж ахуй зэрэг салбарт олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарч магадгүй юм. Хувийн хэвшлийнхэн нийтийн сайн сайхны төлөө бус, хувийн ашгаа урьтал болгоод байна гэх хардлага, болгоомжлол байнга гардаг байна.

Хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх асуудал: Зарим тохиолдолд хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоотой төслүүд ил тод бус байх явдал байдаг. Энэ нь олон нийтийн хяналтыг бууруулж, ялангуяа төсөл хангалтгүй гүйцэтгэлтэй, эсхүл томоохон сорилттой тулгарвал хэн хариуцлага хүлээх нь тодорхой бус байдаг.

Урт хугацааны санхүүгийн үүрэг: Засгийн газрууд хувийн хэвшлийн байгууллагуудын өмнө урт хугацааны санхүүгийн үүрэг хүлээдэг тул ирээдүйд төсвийн уян хатан байдлыг хязгаарлаж болзошгүй. Ялангуяа хүлээгдэж буй, өгөөжөө өгдөггүй төслүүд ихээхэн хүндрэл бий болгох төдийгүй урт хугацаандаа төсөвт асар том дарамт болох нь бий.

1.7.Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт

Монгол Улсад төрийн зарим зорилт, чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхтэй холбогдсон харилцааг дараах хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль (1993);
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль (2022);
- Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хууль (2024);
- Өрсөлдөөний тухай (2010);
- Төсвийн тухай хууль (2011);
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, (Улсын Их Хурлын 2009 оны 64 дүгээр тогтоол);
- бусад.

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийг[7] Улсын Их Хурлын 2009 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан бөгөөд уг баримт бичгийн 6.1.1-д заасныг баримтлан Улсын Их Хурлаас 2010 онд Концессын тухай хуулийг батлан гаргасан байдаг. Концессын тухай хууль батлагдсанаас хойш төрийн өмчийн концессын “барих-шилжүүлэх” болон “барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр нийт 25.5 их наяд төгрөг буюу 8.9 тэрбум ам долларын өртөг бүхий 60 төслийн гэрээ байгуулагдсан бөгөөд нийт гэрээний 60 гаруй хувь буюу 40 төсөл нь концессын “барих-шилжүүлэх” төрлийн, 20 төсөл нь “барих-ашиглах-шилжүүлэх” төрлийн гэрээ байжээ. Концессын тухай хуульд заасан “барих-шилжүүлэх” төрөл нь олон улсын жишигт нийцсэн төр, хувийн хэвшлийн төрөл биш, төсвийн хөрөнгө оруулалтаас ялгаагүй нөхцөл байдалтай, улсын төсөвт ихээхэн ачаалал, дарамт үүсгэж байсан байна.

[7] Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоол. https://legalinfo.mn/mn/detail?lawId=203312&showType=1

Мөн Концессын тухай хуульд төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар тодорхой зохицуулалт байхгүй байсан тул тус хуулийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн суурь зарчмын хүрээнд өөрчлөн шинэчлэх, ойлгомжгүй, тодорхойгүй зохицуулалтыг бусад хууль тогтоомжтой уялдуулах, нэр томьёог жигдлэх, олон улсын жишиг, практик шаардлагад нийцсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж Засгийн газар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж батлуулсан байдаг.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн[8] 19 дүгээр зүйлд "1.Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно. 2.Төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг биелүүлж, уг ажлаа Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцна." гэж заасан.

2010 онд батлагдсан **Өрсөлдөөний тухай хуулийн**[9] хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл олгох, бүртгэл явуулах, төлбөр, хураамж авахыг хориглоно." Заасан бөгөөд Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага хуульд зааснаас бусад тохиолдолд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглохоор тусгасан. Үүнд:

- аж ахуй эрхлэгчийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахыг хориглосон буюу хязгаарласан;
- аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнээ нэг зах зээлээс нөгөөд борлуулахыг хориглосон буюу хязгаарласан;
- тухайн зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хориглосон буюу хязгаарласан, эсхүл түүнийг зах зээлээс шахан гаргахад чиглэсэн;
- бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахад, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн;
- зах зээлийг нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр, төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилахад чиглэсэн;
- аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнийг бусад байгууллага, аж ахуй эрхлэгчид зээлээр олгоход чиглэсэн;
- аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн.

2011 онд батлагдсан ***Төсвийн тухай хуулийн***[10] "Төр ба хувийн хэвшлийн түншлэл" гэсэн 30 дугаар зүйлд төр, хувийн хэвшлийн гэрээ, түүнийг хэрэгжүүлэх суурь зохицуулалт болон хориглох зүйлийг тусгасан байна.

[8] Монгол Улсын Засгийн газрын тухай хууль. https://legalinfo.mn/mn/detail?lawId=344
[9] Өрсөлдөөний тухай хууль. https://legalinfo.mn/mn/detail/12
[10] Төсвийн тухай хууль. https://legalinfo.mn/mn/detail/12254

Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль[11] нь 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хуулиар нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшил хамтран хэрэгжүүлэх түншлэлийн төслийг төлөвлөх, боловсруулах, үнэлэх, судлан шинжилсний үндсэн дээр төслийг сонгох, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах, түншлэлийн гэрээг байгуулах болон хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль[12] нь 2024 оны 04 сарын 19-ний өдөр батлагдсан бөгөөд 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ. Тус хуулиар мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, түүнд тавигдах шаардлага, мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдал, зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхойлох, төрийн байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Түүнчлэн Хөрөнгө оруулалтын тухай, Чөлөөт бүсийн тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай зэрэг 10 гаруй хуулиар тухайн төсөл, арга хэмжээг концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн дагуу, эсхүл түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэхээр заасан байдаг.

1.8.Монгол Улсад тулгарч буй бэрхшээлүүд

Монгол Улсад хэрэгжиж буй дэд бүтцийн зарим томоохон төслүүд нь гол төлөв төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжсэн байдаг. Эдийн засаг, хөгжлийн яамны албан ёсны цахим хуудсанд мэдээлснээр одоогийн байдлаар Монгол Улс дараах концессын гэрээг байгуулан хэрэгжүүлж байна[13]:

1) "Туул - Сонгино усны нөөцийн цогцолбор төсөл"-ийн концессын гэрээ;
2) "Тэлмэний дулааны цахилгаан станц төсөл"-ийн концессын гэрээ;
3) "Багануурын цахилгаан станц" төсөл;
4) "Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концессын гэрээ;
5) "Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км авто зам төсөл"-ийн концессын гэрээ;
6) "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концессын гэрээ;
7) "Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам төсөл"-ийн концессын гэрээ;
8) "Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийн концессын гэрээ;
9) "Зорчигчийн хоол бэлтгэх зориулалт бүхий катерингийн барилгыг барьж, үйлчилгээ үзүүлэх төсөл"-ийн концессын гэрээ;

[11] Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532629445571
[12] Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хууль. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140189607421
[13] Эдийн засаг, хөгжлийн яамны цахим хуудас. https://med.gov.mn/concess

10) "Дашинчилэн - Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн - Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концессын гэрээ;
11) Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам төсөл;
12) "Рашаант дахь улсын нөөцийн агуулах төсөл"-ийн концессын гэрээ.

Гэвч Монгол Улсад “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого” батлагдаж хэрэгжсэн сүүлийн 20 орчим жилийн хугацаанд энэ чиглэлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хууль эрх зүйн хүрээнд тодорхойгүй, зөрчилтэй зохицуулалтуудаас шалтгаалан санхүүжилтийн болон хяналт, гүйцэтгэлийн тодорхой хүндрэл, бэрхшээлтэй асуудлууд тулгарсаар ирсэн.

Энэ байдалд дүгнэлт хийж Засгийн газраас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулан мөрдөж эхлээд жил хүрэхгүй хугацаа өнгөрч байна. Тус хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн боловч энэ онд Улсын Их Хурлын ээлжит сонгууль давхацсан бөгөөд шинэ Засгийн газар бүрдэн ажлаа эхлээд удаагүй байна. ***Тиймээс хуулийн хэрэгжилтэд одоогоор дүн шинжилгээ хийх цаг хугацааны боломж хараахан бүрдээгүй байна.*** Түүнчлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуулийг мөнхүү батлаад байгаа бөгөөд тус хууль ирэх оны 01 сарын нэгнээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ. Төрөөс зарим зорилт, чиг үүргээ хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх нь эдийн засгийн үр ашигтай, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чухал ач холбогдолтой арга хэрэгсэл юм. Иймээс хууль эрх зүйн зохицуулалтыг тодорхой, ойлгомжтой болгосноор төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр дүн, үр нөлөөг илүү ихээр сайжруулж чадна.

Хоёр. ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД ХУВИЙН ХЭВШИЛТЭЙ ӨРСӨЛДӨХГҮЙ БАЙХ ЗАРЧМЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Олон улсад төрийн байгууллага хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг тодорхойлохдоо “өрсөлдөөнд төвийг сахих зарчим” (principle of competitive neutrality) гэж тодорхойлдог.

Өрсөлдөөнд төвийг сахих зарчим нь өрсөлдөөний эрүүл орчныг бүрдүүлэх, монополчлолоос урьдчилан сэргийлэхийн тулд хувийн хэвшлийн болон төрийн өмчит (болон төрийн өмчийн оролцоотой) хуулийн этгээдүүдийн тэгш өрсөлдөөний нөхцөлийг хадгалахыг ойлгоно. Эдийн засгийн үйл ажиллагаанд төр оролцох нь ихэвчлэн төрийн өмчит (төрийн өмчийн оролцоотой) хуулийн этгээдүүд шударга бус давуу тал олгох аюултай. Үүнийг шийдвэрлэхийн тулд өрсөлдөөнд төвийг сахих нь төрийн өмчит хуулийн этгээдүүдийг хэт давуу талгүйгээр ажиллуулах, органик эдийн засгийн хөгжлийг дэмжих, монополчлолын хяналтаас хамгаалах зорилготой юм.[14]

Энэхүү зарчим нь төрийн өмчит хуулийн этгээдүүд идэвхгүй, идэвхтэй арга хэмжээ авах замаар давуу тал олгохгүй байхыг шаарддаг. Идэвхгүй арга хэмжээ нь засгийн газрууд шударга бус давуу тал олгох, монопол байдлыг бий болгох хууль тогтоомж, захиргааны актуудыг батлах гэх мэт аж ахуйн нэгжүүдэд ашигтай байдлаас татгалзах явдал юм. Идэвхтэй арга хэмжээ нь төрийн болон арилжааны ашиг сонирхлын давхцалыг бууруулах, ялангуяа төрийн өмчит хуулийн этгээдүүд идэвхтэй ажиллаж байгаа салбаруудад өрсөлдөөнийг идэвхтэй дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэгдэж байна. Засгийн газрууд дээрх хоёр төрлийн арга хэмжээг хэрэгжүүлснээр шударга өрсөлдөөний орчныг бүрдүүлж, хувийн хэвшилд хохирол учруулахгүй, эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах боломжтой.[15]

Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллагаас засгийн газруудад хандаж “Өрсөлдөөний төвийг сахих тухай Зөвлөлийн зөвлөмж”-ийг [16] 2021 онд баталсан. Тус зөвлөмжид:

1) аж ахуйн нэгжүүд одоо байгаа, эсхүл өрсөлдөх боломжтой зах зээлд хамаарах хууль эрх зүйн орчин нь төвийг сахисан, өрсөлдөөн нь үндэслэлгүй саад, хязгаарлалт, гажуудалд өртөхгүй байхыг баталгаажуулахыг (түүний дотор өрсөлдөөнийг үгүйсгэсэн монополын эсрэг хуультай байх, өрсөлдөөн, дампуурлын болон зохицуулалтын хуулиудыг хэрэглэхэд өрсөлдөөний төвийг сахих, төрийн худалдан авалтад нээлттэй, шударга, ялгаварлан гадуурхахгүй, ил тод өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх);

2) зах зээл дэх аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг гажуудуулах арга хэмжээг боловсруулахдаа өрсөлдөөний төвийг сахихыг (өрсөлдөөнийг гажуудуулж, зарим аж ахуйн нэгжийг бусдаас сонгон ашиг тусыг нь хүртэх үндэслэлгүй давуу тал олгохоос зайлсхийх, аж ахуйн нэгжид хүлээлгэсэн төрийн үйлчилгээний аливаа үүргийн нөхөн олговрыг

[14] The Principle of Competitive Neutrality: Theory and Practice. Beka Khitiri. Journal of Law, No2, 2021. P. 152-164. https://n9.cl/uu5fy
[15] Мөн тэнд.
[16] OECD Recommendation of the Council on Competitive Neutrality. https://tinyurl.com/tbdwsywd

үйлчилгээний өртөгт тохирсон, пропорциональ байхаар хязгаарлах, бүтцийн дүрэм, удирдлагын дүрмийг батлах зэрэг орно. Өрсөлдөөнийг гажуудуулах үндэслэлгүй давуу талыг олгодоггүй төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд) зөвлөсөн байна.

Энэхүү судалгаанд хамрагдсан Австрали, Филиппин, Финланд улсуудын эрх зүйн зохицуулалт нь төрийн байгууллага хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх буюу өрсөлдөөнд төвийг сахих зарчмыг хангах нийтлэг зорилготой. Тодруулбал, Австрали Улсын Өрсөлдөөн ба хэрэглэгчийн хууль, Филиппин болон Финланд улсуудад Өрсөлдөөний тухай хуулиудаар төрийн болон хувийн өмчийн хуулийн этгээдүүдийн зах зээлийн өрсөлдөөнд адил тэгш оролцохыг хуульчилсан. Австрали болон Филиппин улсуудад Өрсөлдөөний үндэсний бодлогыг батлан хэрэгжүүлж байна.

Өөрийн орны зах зээлийн өрсөлдөөнд төвийг сахих, хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавихад Австралийн Өрсөлдөөний болон хэрэглэгчийн хороо (ACCC), Филиппиний Өрсөлдөөний хороо (PCC) болон Финландын Өрсөлдөөн, хэрэглэгчийн газар (FCCA) хэрэгжүүлдэг.

Судалгаанаас үзэхэд, Австрали болон Филиппин улсуудад өрсөлдөөний шударга байдлыг хангах өргөн хүрээний зохицуулалтад тулгуурласан байна. Тухайлбал, Австрали Улсын Өрсөлдөөний үндэсний бодлогоор их хэмжээний ашиг олох зах зээлд төрийн өмчийн хуулийн этгээд бизнес эрхлэхгүй байхыг, Өрсөлдөөн ба хэрэглэгчийн тухай хуулиар зах зээлд нөлөө бүхий корпорацууд, төрийн өмчийн хуулийн этгээдүүд өрсөлдөгчөө алдагдалд оруулах, зах зээлд нэвтрэхийг хориглох, дэд бүтцийн салбарт хувийн хэвшил нэвтрэх боломж олгохыг хуульчилжээ.

Филиппин Улсын Үндэсний өрсөлдөөний бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг болсон Өрсөлдөөний тухай хуулиар төрийн өмчит болон хяналттай корпорацууд (GOCCs) нь үнэ тогтоох, зах зээлийн манипуляц хийх, зах зээлд ноёрхол тогтоох зэргээр өрсөлдөөнийг сааруулахыг хориглодог.

Харин Финланд Улсад нягтлан бодох бүртгэлээр дамжуулан ил тод байдлыг хангах арга хэрэгслийг нэвтрүүлснээрээ онцлог байна. Тус улсад нийтийн аж ахуйн нэгжүүд зах зээл дэх эдийн засгийн үйл ажиллагаагаа бусад үйл ажиллагаанаасаа ялгаж нягтлан бодох бүртгэлийг тайлагнахыг шаардаж, түүнд нь Финландын Өрсөлдөөн, хэрэглэгчийн газар хяналт тавьдаг. Мөн тус газар нь өрсөлдөөний гажуудуулсан зөрчлийг хэлэлцээр хийх замаар арилгадаг.

2.1.Австрали Улс

Австрали Улс төрийн өмчит хуулийн этгээд хувийн өмчийн хуулийн этгээдтэй өрсөлдөхгүй байх зарчмыг дараах хоёр арга замаар хэрэгжүүлдэг:

Нэгдүгээрт, Өрсөлдөөний үндэсний хууль тогтоомжоор дамжуулан хэрэгжүүлэх - Өрсөлдөөн ба хэрэглэгчийн хууль (Competition and Consumer Act 2010[17]) нь төрийн болон хувийн өмчийн хуулийн этгээдэд адил тэгш үйлчлэх ба төр, түүний өмчийн оролцоотойгоос үл хамааран тус хуулийг дагаж мөрддөг.

[17] Competition and Consumer Act 2010. https://www8.austlii.edu.au/

Хоёрдугаарт, Холбооны болон мужийн түвшний Засгийн газрууд Өрсөлдөөний зарчмын гэрээ (Competition Principles Agreement) гэж нэрлэгддэг Өрсөлдөөнд төвийг сахих бодлогыг батлан хэрэгжүүлсэн.

Эдгээр шинэчлэлийн үндэс суурь нь 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхээр хувийн секторын зах зээлд төрийн өмчийн хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлж байв. Тэр үед төрийн өмчийн хуулийн этгээд нь татварын хөнгөлөлттэй нөхцөлтэй, төрийн хяналт шалгалтаас дархлаатай, ашиг олох шаардлагагүй зэрэг хувийн өмчийн хуулийн этгээдээс илүү давуу талуудыг ашигладаг байв.

Эдгээрийн үр дүн нь үр ашиггүй төрийн өмчийн хуулийн этгээдүүд илүү үр ашигтай ажиллах өрсөлдөгчдөөсөө доогуур үнэ ханш тогтоож, тэднээс зах зээлийг булаан авсан байна.[18]

Австрали Улс дээрх гажуудлыг арилгах зорилгоор 1990-ээд оны эхээр микро эдийн засгийн шинэчлэл хийж өрсөлдөөнийг бодлогын түвшинд нарийвчлан зохицуулах шаардлагатай болсон. Энэ хүрээнд 1993 онд Австрали Улсын Ерөнхий сайдын санаачилгаар тус улсын үндэсний өрсөлдөөний нөхцөл байдалд бие даасан шалгалтыг профессор Фредерик Хилмерээр ахлуулсан багаар гүйцэтгүүлсэн бөгөөд тус шалгалтын тайланг Хилмерийн тайлан (Hilmer Report 1993[19]) хэмээн нэрлэдэг.

Шалгалтын үр дүнд төрийн өмчийн хуулийн этгээдээр бизнес эрхэлснээр хувийн хэвшилтэй тэгш өрсөлдөхгүй, давуу байдалтай байгааг, хувийн хэвшлийн ашиг олох боломж хязгаарлагдах, төрийн зардал нэмэгдэн үр ашиггүй ажиллаж, эргээд төрөөс татаас авч буйг илрүүлжээ. Иймд Хилмерийн тайлангаар дараах зөвлөмжийг гаргасан байна:

- төрийн өмчит хуулийн этгээдийг бизнесийн салбарт шударга бус давуу тал эдлүүлэхгүйн тулд өрсөлдөөний төвийг сахисан байдлыг нэвтрүүлэх;
- төрийн өмчит монопол хуулийн этгээдүүдийн бүтцийг өөрчлөх замаар өрсөлдөөнийг нэмэгдүүлэх;
- үндэсний хэмжээний дэд бүтцийн салбарт хувийн өмчийн гуравдагч этгээд нэвтрэх зохицуулалтыг боловсруулах;
- өрсөлдөөнийг хязгаарласан бүх хуулийг эргэн харах шаардлагатай тухай дурдсан байна.

Өрсөлдөөний үндэсний бодлого

Хилмерийн тайлангийн зөвлөмжид үндэслэн Өрсөлдөөний үндэсний бодлого (National Competition Policy)[20] -ыг баталсан. Уг бодлогын хүрээнд өмнө дурдсан Өрсөлдөөний зарчмын гэрээг Австрали Улсын Ерөнхий сайд, бүх мужуудын Ерөнхий сайд нар гарын үсэг зурж баталсан.[21] Энэхүү гэрээгээр төрийн өмчийн хуулийн этгээд

[18] Roundtable on competitive neutrality in competition enforcement - Note by Australia. OECD. 16-18 June 2015. https://tinyurl.com/42xf7tm8
[19] Hilmer Report 1993. www.australiancompetitionlaw.org
[20] National Competition Policy. http://ncp.ncc.gov.au/
[21] National Competition Policy. http://ncp.ncc.gov.au/pages/overview

нь өрсөлдөөнд давуу тал эдлэхгүй байх, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй ижил татвар төлөх, хууль эрх зүйн давуу тал эдлэхгүй байх үүрэг хүлээсэн.[22]

Өрсөлдөөний үндэсний бодлогын зорилго нь төр хувийн хэвшилтэй өрсөлдөн бизнес эрхэлсний улмаас зах зээлд гарч буй гажуудлыг арилгах юм. Тухайлбал, их хэмжээний ашиг олох зах зээлд төрийн өмчийн хуулийн этгээд бизнес эрхлэхгүй байж тухайн зах зээлийг хувийн хэвшилд үлдээнэ.

Өрсөлдөөний үндэсний бодлогыг төрийн бүх шатны байгууллагууд хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд зөвхөн ***төр хувийн хэвшилтэй өрсөлдөх нөхцөл байдал үүссэн үед хэрэглэдэг*** онцлогтой.

Харин ашгийн бус, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх болон алдагдлаа нөхөх төдий үйл ажиллагаа явуулахыг төрд зөвшөөрдөг байна.

Өрсөлдөөн ба хэрэглэгчийн тухай хуулийн зохицуулалт

Өрсөлдөөн ба хэрэглэгчийн тухай хууль нь төрийн өмчит хуулийн этгээд зах зээлд шударга бус давуу байдал олгохгүйн тулд өрсөлдөөнт зах зээл хэрхэн ажиллах ёстойг зохицуулсан тодорхой заалтуудыг тусгаснаар төр, хувийн хэвшил хоорондоо өрсөлдөхгүй байх зарчмыг хэрэгжүүлдэг. Энэ зарчимтай холбоотой тус хуулийн үндсэн хэсгүүд нь:

Зах зээлийн эрх мэдлээ буруугаар ашиглах: Өрсөлдөөн ба хэрэглэгчийн тухай хуулийн 46 дугаар зүйлд зах зээлд нөлөө бүхий корпорацууд болон төрийн өмчийн хуулийн этгээдүүд өрсөлдөгчөө алдагдалд оруулах, зах зээлд нэвтрэхийг хориглох зорилгоор эрх мэдлээ ашиглахыг хориглодог.[23]

Энэ нь хувийн хэвшлийн өрсөлдөгчдийг зах зээлд оруулахгүйн тулд зах зээлийн үнээс доогуур үнэ тогтоох зэргээр өрсөлдөөнийг шударга бусаар хязгаарласан зан үйлээс урьдчилан сэргийлэх зорилготой.

Дэд бүтцийн салбарт нэвтрэх: Өрсөлдөөн ба хэрэглэгчийн тухай хуулийн 44АА дугаар зүйл нь монопол, түүний дотор төрийн өмчийн хуулийн этгээдүүд үйлчилгээ үзүүлж байгаа дэд бүтцийн салбарт хувийн хэвшил нэвтрэх боломж олгох тухай заасан. Ийнхүү боломж олгосноор өрсөлдөөний талбарыг тэгшитгэх, улмаар шударга өрсөлдөөнийг дэмжих, төрийн өмчит хуулийн этгээдүүд зарим салбарт шударга бусаар монополчлохоос урьдчилан сэргийлэх зорилготой.[24]

Австралийн Өрсөлдөөн ба хэрэглэгчийн хороо (Australian Competition and Consumer Commission)[25] нь үндэсний хэмжээнд өрсөлдөөнд төвийг сахих зарчмын хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй хараат бус төрийн байгууллага юм. Өрсөлдөөн ба хэрэглэгчийн тухай хуульд зааснаар тус байгууллага нь:

- шударга өрсөлдөөнийг дэмжих;
- шударга худалдааг дэмжих;
- хэрэглэгчийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

[22] Competition Principles Agreement 1995. https://n9.cl/w8hnm
[23] Competition and Consumer Act 2010 SECT 46. Misuse of market power https://n9.cl/rmhlg
[24] Competition and Consumer Act 2010 SECT 44AA. https://n9.cl/f0rvrg
[25] Australian Competition and Consumer Commission https://www.accc.gov.au/

Тухайлбал, Өрсөлдөөн ба хэрэглэгчийн тухай хуулийн хэрэгжилтийг орон даяар хангуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд төрийн өмчийн болон хувийн өмчийн хуулийн этгээд, төрийн бүх шатны байгууллагад үе шаттай сургалт зохион байгуулах, хэрэглэгчдэд туслах, хууль зөрчсөн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авч хянан шийдвэрлэх, шаардлагатай бол албадлага хэрэглэх зэрэг эрхтэй.

Өрсөлдөөний Үндэсний Зөвлөл (National Competition Council)[26] нь Өрсөлдөөн ба хэрэглэгчийн тухай хуульд зааснаар монопол өрсөлдөөнд гуравдагч этгээдийн оролцоог хангах талаар зөвлөмж өгөх үндсэн чиг үүрэгтэй. Энэ зөвлөл нь Засгийн газрын агентлагийн статустай ажилладаг. Австрали Улсын мужуудад зөвлөгөө өгч, мэдээллээр хангадаг.

Өрсөлдөөнт төвийг сахих гомдол шийдвэрлэлт

Австралийн Өрсөлдөөнт төвийг сахих гомдлын алба (Australian Government Competitive Neutrality Complaints Office AGCNCO) [27] нь төрийн өмчийн хуулийн этгээдүүд өрсөлдөөнд төвийг сахих үүргээ биелүүлээгүйгээс үүдэлтэй шударга бус өрсөлдөөний талаарх гомдлыг шалган шийдвэрлэдэг бие даасан байгууллага юм.

Тус алба нь иргэн, хуулийн этгээдээс төрийн өмчийн хуулийн этгээд төрийн нэрийн өмнөөс хувийн өмчийн хуулийн этгээдүүдтэй шударга бусаар өрсөлдөж байгаа талаарх өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж, гомдолд дурдсан асуудал тус бүрээр Сангийн сайд, Засгийн газарт зөвлөгөө өгөх чиг үүрэгтэй. Харин Засгийн газар энэ зөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэггүй.

Гомдол дараах гурван төрөлд хамаарна. Үүнд:

1) төрийн өмчийн хуулийн этгээд өрсөлдөөний төвийг сахих зохицуулалтыг дагаж мөрдөөгүй бол;
2) өрсөлдөөний төвийг сахих зохицуулалт нь төрийн өмчийн хуулийн этгээдийн давуу талыг арилгахад үр дүнгүй бол;
3) төрийн өмчийн хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь өрсөлдөөний төвийг сахих зохицуулалтад хамаарахгүй байгаа бол.

Гомдол гаргахаар төлөвлөж буй иргэн, хуулийн этгээд нь эхлээд гомдлын албаны мэргэжилтнүүдээс зөвлөгөө авна. Энэ нь тухайн асуудал Өрсөлдөөний төвийг сахих бодлогын хүрээнд хамаарах эсэхийг тодруулахад тусалж, албан ёсны хянан шийдвэрлэх ажиллагаа шаардлагагүйгээр асуудлыг шийдвэрлэх боломж олгодог.

Албан ёсны гомдлыг Гомдлын албаны цахим хуудсаар дамжуулан бичгээр гаргана. Гомдлын алба нийтэд ил болгож, тухайн асуудалтай холбоотой сонирхогч талуудыг хариу тайлбар, мэдээлэл ирүүлэхийг урьдаг.

Харин Гомдлын албаны эрхлэх асуудлын хүрээний бус гомдол ирүүлсэн бол энэ тухай гомдол гаргагчид бичгээр зөвлөмж өгдөг.

[26] National Competition Council. https://ncc.gov.au/
[27] Australian Government Competitive Neutrality Complaints Office. www.pc.gov.au

Гомдлын алба гомдол хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор Засгийн газарт тайлагнах журамтай. Нийтийн эрх ашгийг хөндсөн, нарийн төвөгтэй асуудлын талаарх тайланг Засгийн газар хүлээн авч нийтийн сонсгол зохион байгуулж болно.[28]

2.2.Филиппин Улс

Филиппин Улсын эдийн засаг сайжрахгүй байгааг төрийн бодлоготой холбож тайлбарладаг. Ялангуяа улс орны эдийн засгийн үр ашиггүй байдал, түүний дотор өрсөлдөөнийг ихээхэн хэмжээгээр саатуулах, хязгаарлах, бууруулах бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй зүйлс нь засгийн газрын агентлаг, орон нутгийн засаг захиргааны нэгж, засгийн газрын хяналтад байдаг корпорацуудын удаан хугацаанд хэрэгжүүлж ирсэн бодлого, журам, дүрэм, үйл явцаас үүдэлтэй гэж үздэг.

Тус улсын Засгийн газрын үйл ажиллагаа нь төрийн өмчит болон хувийн компаниудын хооронд зах зээл дэх өрсөлдөөний түвшинд нөлөөлдөг. Тухайлбал, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд зах зээлд илүү давуу эрхийг эдэлж байсан бөгөөд энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд зүй бус давуу байдал бий болгож, зах зээл дэх өрсөлдөөнийг гажуудуулах нөхцөл бүрдсэн. Засгийн газраас төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд татаас, татварын таатай нөхцөл, зээлийн баталгаа, тусгай зөвшөөрөл зэрэг хэлбэрээр өрсөлдөөний давуу талыг бий болгодог. Энэ асуудлыг шийдэх зорилгоор хэд хэдэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснийг тоймлон оруулав.

Өрсөлдөөний тухай хуулийн зохицуулалт

Филиппин Улс нь 2015 онд зах зээл дээрх шударга өрсөлдөөнийг дэмжих зорилготой Өрсөлдөөний тухай хуулиа баталсан.[29] Тус улсын Өрсөлдөөний тухай хуулийн хамрах хүрээ нь тус улсад аливаа үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, байгууллагуудад хамаарна гэдгийг тодорхой заасан байдаг. Мөн засгийн газрын эзэмшдэг болон хяналтад байдаг байгууллагуудад хамаардаг. Тус хуульд төрөөс хувийн хэвшлийн байгууллагуудтай өрсөлдөхийг шууд хориглоогүй ч давамгайлсан буюу хязгаарласан хэлцлээс үүсэх монопол, шударга бус үйлдлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой заалтуудыг тусгасан байна.

Өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилтийг Үндэсний өрсөлдөөний бодлогоор дамжуулан зах зээлийн шударга өрсөлдөөнийг хангах, хөрөнгө оруулалт, инновацыг дэмжих, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх худалдааны бодлогыг боловсронгуй болгох орчныг бүрдүүлэх замаар тус хуулийн хэрэгжилтийг хангадаг.

Тухайлбал, Өрсөлдөөний тухай хуулийн 15 дугаар зүйлд төрийн өмчит болон хяналттай корпорацууд (GOCCs) нь үнэ тогтоох, зах зээлийн манипуляц хийх, зах зээлд ноёрхол тогтоох зэрэг өрсөлдөөнийг сааруулахыг хориглодог. Мөн өрсөлдөөнийг хязгаарлах гэрээ хэлцэл хийхгүй байх, зах зээлд шударга өрсөлдөөнтэй байх үүрэгтэй бөгөөд хувийн хэвшилтэй өрсөлдөхдөө өрсөлдөөний шударга зарчмуудыг баримтлах шаардлагатай гэж заасан байдаг.

[28] Roundtable on competitive neutrality in competition enforcement - Note by Australia. OECD. 16-18 June 2015. https://tinyurl.com/42xf7tm8
[29] Philippine Competition Law (R.A. 10667). https://urlshort.app/B5LF3A

Төрийн өмчит үйлдвэрүүд ба Өрсөлдөөний үндэсний бодлого

Филиппин Улс зах зээл дээрх тодорхой бизнес, цахилгаан эрчим хүчний үйлчилгээг төр эзэмшихийн сөрөг нөлөөг эртнээс хүлээн зөвшөөрсөн бөгөөд тус салбарт чухал шинэчлэлүүдийг хийж өрсөлдөөнд илүү нөхөрсөг эдийн засгийн нөхцөл байдал бий болгохын тулд зах зээлийн гажуудал, хязгаарлалтуудыг залруулах арга хэмжээ авч эхэлсэн.

Жил ирэх тутам төрийн өмчит үйлдвэрийн газрууд өсөн нэмэгдэж байгаатай холбоотой тэдний зохисгүй өрсөлдөөний улмаас 1988 онд Филиппиний Ерөнхийлөгчийн 59 дүгээр тушаалаар төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хувийн хэвшилтэй ижил тэгш өрсөлдөх, төрийн өмчит, хяналттай корпорацуудын үйл ажиллагааг тодорхой зааглах, өрсөлдөөний зарчмуудыг тусгах чиглэл өгсөн.

2011 онд батлагдсан Төрийн өмчит, хяналттай корпорац (GOCC)-ын тухай хуулийн дагуу Засгийн газрын эзэмшил, хяналттай корпорацын Удирдлагын Комиссыг байгуулсан. Энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн цаашдын шинэчлэлийг хийхэд түлхэц болсон аж.

Үүний дараа Ерөнхийлөгчийн Тамгын газрын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 44 дүгээр захирамжаар “Өрсөлдөөний үндэсний бодлого”-ыг баталсан бөгөөд төрийн байгууллагуудад энэхүү бодлогыг баримтлах чиглэл өгчээ.[30]

Өрсөлдөөний тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх механизм нь Үндэсний өрсөлдөөний бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг болсон. Үндэсний өрсөлдөөний бодлогыг боловсруулахдаа өрсөлдөөнд төвийг сахих бодлого, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, өрсөлдөөнд саад учруулахгүй байх төрийн зохицуулалт, бүтцийн саад тотгорыг арилгах зэрэг бусад ижил чухал бүрэлдэхүүн хэсгүүдийг бий болгож, тэдгээрийг зохицуулах, хянах үр дүнтэй механизмыг бий болгосон.[31]

Үндэсний өрсөлдөөний бодлогыг нь дараах чиглэлийн дагуу боловсруулсан:

- өрсөлдөөнийг дэмжсэн бодлого, оролцоог санаачлан хэрэгжүүлэх;
- өрсөлдөөнд төвийг сахисан байдлыг дэмжих;
- Өрсөлдөөний хороо нь тус бодлогыг хэрэгжүүлэх, Өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Өрсөлдөөний тухай хууль болон Үндэсний өрсөлдөөний бодлогыг хэрэгжүүлэх Филиппиний Өрсөлдөөний хороо үйл ажиллагаа явуулдаг. Тус хороо нь өрсөлдөөнд төвийг сахих байр суурийг дэмжихийн тулд Засгийн газрын эзэмшдэг, хяналтад байдаг корпорацуудын мандатыг хянан хэлэлцэж Төрийн өмчит, хяналттай корпорац (GOCC)-ын тухай хуулийн дагуу өрсөлдөөнтэй холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх талаар Ерөнхийлөгчид санал болгох үүрэгтэй. Ерөнхийлөгчийн 2021 оны 477 дугаар тушаалаар үндэсний бүх төрийн агентлагууд болон орон нутгийн засаг захиргааны нэгжүүдэд Үндэсний өрсөлдөөний бодлогыг хэрэгжүүлэхийг тушаасан бөгөөд энэ нь өрсөлдөөнд төвийг сахих бодлогыг улам бэхжүүлэхэд түлхэц болсон.

[30] National Competition Policy gets Palace nod for public sector rollout. https://urlshort.app/O4A55P
[31]The National Competition Policy of the Philippines. https://urlshort.app/EYMUAB

Филиппиний Өрсөлдөөний хороо

Өрсөлдөөний тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар тус хуулийн хэрэгжилтийг хангах, өрсөлдөөнтэй холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор Өрсөлдөөний хороо байгуулсан. Филиппиний Өрсөлдөөний хороо нь 2016 онд байгуулагдсан бөгөөд анхан шатны эрх мэдэл бүхий бие даасан хагас шүүхийн (quasi-judicial body) байгууллага юм. Тус хороо нь хорооны дарга болон дөрвөн комиссараас бүрдэх ба Засгийн газрын нарийн бичгийн дарга, дэд нарийн бичгийн даргатай дүйцэх зэрэгтэй байна. Хорооны гишүүдийг ерөнхийлөгч 7 жилийн хугацаагаар томилдог.[32]

Филиппиний Өрсөлдөөний хороо нь Үндэсний Өрсөлдөөний бодлогын хэрэгжилтийг хянах бөгөөд Филиппиний 2016-2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд Өрсөлдөөний бодлогын тухай тусгай бүлгийг боловсруулж оруулсан байна. Мөн “2023-2028 оны Хөгжлийн төлөвлөгөө”-нд тусгаж өгсөн.

Тус хороо нь Өрсөлдөөний тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны өрсөлдөөнтэй холбоотой үйл ажиллагааны үр дагаврын талаар Засгийн газарт зөвлөгөө, зөвлөмж өгөх байдлаар ажилладаг бөгөөд өрсөлдөөний бодлогын талаар тогтмол мэдээлэх замаар хууль тогтоох үйл явцад идэвхтэй оролцдог. Эдгээр санаачилга нь өрсөлдөөний асуудлуудыг шийдвэрлэх, бизнес эрхлэхэд хялбар болгох зорилгоор агентлагууд хоорондын хамтын ажиллагааг бий болгодог бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг:

- өрсөлдөөнийг дэмжих талаар санал, дүгнэлт боловсруулах;
- өрсөлдөөнтэй холбоотой үйл ажиллагаа, хөтөлбөрийн тухай алба, агентлагуудад зөвлөмж өгөх;
- өрсөлдөөний үр нөлөөний үнэлгээгээр дамжуулан нэн чухал болон эн тэргүүнд тавигдах салбаруудад нөлөөлөх хууль, дүрэм журмуудыг урьдчилан хянах;
- эн тэргүүнд тавигдах салбаруудын зах зээлийн судалгааг бэлтгэх;
- өрсөлдөөнд төвийг сахих зарчмын талаар сургалт, семинар зохион байгуулах (тухайлбал: төрийн өмчит үйлдвэрүүд, төрийн хяналтын корпорацууд, хувийн байгууллагуудын удирдах ажилтнуудад зориулсан өрсөлдөөний чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (oecd)-тай хамтран зохион байгуулсан.);
- нэгдэн нийлэх (mergers & acquisitions) үйл явцыг хянах;
- монополын эсрэг хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх;
- шийтгэл ногдуулах зэрэг болно.

2.3.Финланд Улс[33]

Өрсөлдөөний тухай хууль дахь Финландын Өрсөлдөөн, хэрэглэгчийн газрын хяналт

Финланд Улсын Өрсөлдөөний тухай хуулийн[34] 4 дүгээр зүйлд “аж ахуйн нэгж” гэдэгт аливаа хувь хүн, мөн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлдэг нэг буюу хэд хэдэн хувийн болон нийтийн хуулийн этгээдийг хамруулахыг тодорхойлсон. Төсвийн

[32] Philippine Competition Commission (PCC). https://urlshort.app/G1EPUD
[33] The Promotion of Competitive Neutrality by Competition Authorities - Contribution from Finland. OECD. 8 December 2021. https://tinyurl.com/c9yd6n8e
[34] Finnish Competition Act (948/2011). https://n9.cl/lswgm

байгууллага нь хуулийн хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Өрсөлдөөний тухай хуулийн дагуу нийтийн аж ахуйн нэгж байна.

Мөн зүйлд “давамгай байр суурь” (dominant position) гэдгийг бараа, үйлчилгээний тодорхой зах зээлд нэг буюу хэд хэдэн аж ахуйн нэгжүүдийн холбоод тус улсын нийт нутаг дэвсгэрт, эсхүл тодорхой бүс нутагт тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, нийлүүлэлтийн нөхцөлийг хянах, эсхүл түүнтэй адилтгах бусад арга хэрэгслээр тухайн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн түвшинд өрсөлдөөний нөхцөлд нөлөөлөх зорилгоор эзэмшдэг онцгой эрх, эсхүл бусад давамгай байр суурь хэмээн тодорхойлжээ.

2013 онд Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, нийтийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөнд төвийг сахих нөхцөлийг хангах зохицуулалтыг нарийвчилжээ: Финланд Улсад жижиглэнгийн худалдааны зах зээлийн 30-аас доошгүй хувийг эзэлдэг аливаа аж ахуйн нэгж, хэд хэдэн аж ахуйн нэгжүүдийн холбоод нь тус улсын өдөр тутмын хэрэгцээт бараа зах зээлийн 30-аас доошгүй хувийг эзэлдэг бол тус улсын өдөр тутмын хэрэглээний барааны зах зээлд давамгай байр суурь эзлэхийг хуулийн 4а дугаар зүйлд хуульчилсан.

Энэ хуулиар Финландын Өрсөлдөөн, хэрэглэгчийн газар (Finnish Competition and Consumer Authority, FCCA)-т нийтийн аж ахуйн нэгжийн эдийн засгийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтцэд хөндлөнгөөс оролцох эрхийг тус хуулийн 30а дугаар зүйлд олгодог. Тухайлбал, нийтийн аж ахуйн нэгж нь өрсөлдөөнийг гажуудуулсан, эсхүл Хотын захиргааны тухай хууль (Municipalities Act)-д заасан зах зээлийн үнийг тогтоох шаардлагыг зөрчсөн бол тус газраас бараа, үйлчилгээ үзүүлэхэд нь хөндлөнгөөс оролцох эрхтэй.

Финландын Өрсөлдөөн, хэрэглэгчийн газрын өрсөлдөөний гажуудлыг арилгах үндсэн арга хэрэгсэл нь хэлэлцээр хийх бөгөөд нэлээдгүй тохиолдолд зөрчлийг хэлэлцээрээр амжилттай шийдвэрлэсэн туршлагатай аж. Харин хэлэлцээр амжилтгүй болсон бол Финландын Өрсөлдөөн, хэрэглэгчийн газар нь шаардлага, эсхүл хориг тавих бөгөөд эцэст нь торгууль ногдуулах бөгөөд 2021 оны байдлаар тус газраас эдгээр арга хэмжээг хэрэглээгүй байгааг Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) мэдээлж байна. Тус улсад нийтийн аж ахуй нэгжүүд нь Финландын Өрсөлдөөн, хэрэглэгчийн газартай хамтран ажилладаг, хэрэв өрсөлдөөнийг гажуудуулсан нь тогтоогдсон бол хэлэлцээрийн замаар асуудлыг шийдвэрлэдэг.

Өрсөлдөөнд төвийг сахих байдлыг хангах өөр арга хэрэгсэл бол 2020 оноос хэрэгжиж эхэлсэн эдийн засгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлээр тусгаарлах (accounting separation) явдал юм. Өөрөөр хэлбэл, нийтийн аж ахуйн нэгж нь зах зээл дэх эдийн засгийн үйл ажиллагаагаа бусад үйл ажиллагаанаасаа ялгаж нягтлан бодох бүртгэлийг тайлагнах шаардлагатай. Уг арга хэрэгслийн зорилго бол нийтийн аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах бөгөөд үүнд Финландын Өрсөлдөөн, хэрэглэгчийн газар хяналт тавина. ЭЗХАХБ-ын мэдээллээс харахад, аж ахуй нэгжүүдийн эдийн засгийн үйл ажиллагааны ил тод байдал нэмэгдсэн байна.

Финландын Өрсөлдөөн, хэрэглэгчийн газар бол бие даасан үйл ажиллагаа явуулдаг, хараат бус байгууллага бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй

нийтийн аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөнийг гажуудуулж буй аливаа үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох эрхтэй. Харин дараах тохиолдолд тус газраас хөндлөнгөөс оролцохгүй:

- хууль тогтоомжоор шууд заасан үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтцэд;
- иргэдийн сайн сайхан, аюулгүй байдал зэрэг нийтийн ашиг сонирхолтой холбогдох үйл ажиллагаанд.

Хотын захиргааны тухай хуулийн зохицуулалт

Финланд Улсын Хотын захиргааны тухай хуулийн[35] 15 дугаар бүлэгт хотын захиргааны зах зээл дэх үйл ажиллагааг зохицуулах бөгөөд ийм үйл ажиллагааг хязгаарлагдмал хариуцлагатай компани, хоршоо, эсхүл сан зэрэг байгууллагуудад шилжүүлэхийг тус хуулийн 126 дугаар зүйлд шаарддаг.

Хуулийн 126 дугаар зүйлд зааснаар хотын захиргаа нь дараах тохиолдолд зах зээлийн өрсөлдөөнд оролцохгүй:

1) хэрэв хотын захиргаа хуулиар тогтоосон чиг үүргийнхээ хүрээнд оршин суугчдад болон хуулийн дагуу үйлчилгээ авах шаардлагатай бусад хүмүүст үйлчилгээ үзүүлэх бол;
2) хэрэв тухайн чиг үүргийг тус хуулийн 49 дүгээр зүйлд заасан журмын дагуу хамтран ажиллаж, тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчид болон хуулийн дагуу үйлчилгээ авах шаардлагатай бусад хүмүүст хотын захиргааны өөрийн үйлчилгээ хэлбэрээр үзүүлэх бол;
3) хэрэв тухайн чиг үүргийг тус хуулийн 49 дүгээр зүйлд заасан журмын дагуу хамтран ажиллаж байгаа, мөн Худалдан авах ажиллагааны тухай хууль (Procurement Act)-ийн 15, 16, 25, 26 дугаар зүйлд заасан дотоод байгууллага, гэрээт бусад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж байгаа гэрээт бусад байгууллага, эсхүл Нийтийн аж ахуйн салбарын нийтийн гэрээний тухай хууль (Act on Public Contracts in the Utilities Sector)-ийн 27 дугаар зүйлд заасан хараат аж ахуйн нэгж, эсхүл өрсөлдөөнт тендер явуулах үүрэг нь хамтын ажиллагаанд хамаарахгүй бол;
4) хэрэв хотын захиргаа нь боловсролын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, боловсролын байгууллагын тусгай зөвшөөрөл шаарддаг хуульд заасан боловсролын үйлчилгээг зохион байгуулах бол дээрх зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлд заасан бусад ажил, эсхүл боловсролын үйлчилгээ үзүүлэхтэй нягт холбоотой оюутны төсөл хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх бол;
5) хэрэв үйл ажиллагаа нь хуулиар тогтоосон монополын статус дээр суурилсан, эсхүл бодит монопол (natural monopoly)-ийг илэрхийлсэн, эсхүл тэдгээртэй шууд холбоотой үйлчилгээ үзүүлэх бол;
6) хэрэв хотын захиргааны үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, худалдах, эсхүл түрээслэх үйл ажиллагаа нь Газар ашиглалт, барилгын тухай хууль (Land Use and Building Act)-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх бол.

[35] Finnish Municipalities Act (410/2015). https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2015/20150410

Хуулийн 127 дугаар зүйлд зааснаар хотын захиргаа нь дараах тохиолдолд өрсөлдөөнд оролцож болно:

1) үйл ажиллагаа нь ач холбогдолгүй гэж тооцоход;
2) хуулиар өөр этгээдэд тусгайлан үйлчилгээ үзүүлэх, эсхүл ийм үйл ажиллагаатай холбоотой тендерт оролцоход;
3) харьяа компаниудад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлэхэд;
4) Худалдан авах ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан өөрийн байгууллагад, эсхүл Нийтийн аж ахуйн салбарын нийтийн гэрээний тухай хуулийн 25, 27, 28 дугаар зүйлд заасан өөрийн байгууллага, харьяа аж ахуйн нэгж, нийтийн аж ахуйн салбарын нийтийн гэрээний тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хамтарсан үйлдвэрт үйлчилгээ үзүүлэхэд;
5) арилжааны байрыг өөрийн үйл ажиллагаа болон өөрийн харьяа компаниудад ашиглуулах, эсхүл хотын захиргаанаас тендер зарласан үйлчилгээ үзүүлэхэд ашиглах зорилгоор түрээслүүлэхэд;
6) хотын захиргааны, эсхүл түүний харьяа компанид ажилладаг хүмүүст хөдөлмөрийн харилцааны үндсэн дээр үйлчилгээ үзүүлэхэд;
7) үйл ажиллагаа нь Онцгой байдлын тухай хууль (Emergency Powers Act)-д заасан онцгой байдлын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу онцгой байдлын бэлтгэл хийх үүргээ хэрэгжүүлэхэд.

Хотын захиргаа эдгээр нөхцөлд зах зээлийн өрсөлдөөнд үйл ажиллагаа явуулахад Хотын захиргааны тухай хуулийн 128 дугаар зүйлд заасны дагуу зах зээлийн үнийн зарчмыг баримтална. Зах зээлийн үнэ нь тухайн үйлчилгээний үнийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж хэрхэн тогтоосноор илэрхийлнэ. Үнэ тогтоох нь өрсөлдөөнд үйл ажиллагааны хувьсах болон тогтмол зардал, орлого, хөрөнгө оруулалтын зардал, санхүүжилтийн зардал, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолох шаардлагатай. Харин тогтмол, хөрөнгө оруулалтын болон санхүүгийн зардлуудыг зах зээлийн өрсөлдөөнд гүйцэтгэсэн үйл ажиллагааны хуваарийн дагуу тооцоолох шаардлагатай.

Гурав. ТӨРИЙН ТОДОРХОЙ ЧИГ ҮҮРЭГ, ЭРХИЙГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТОЙМ

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан ***Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын***[36] 3.3.2.5-т “Төрөөс стратегийн ач холбогдолтой эдийн засгийн салбар дахь зайлшгүй үйл ажиллагаанаас бусад бизнест оролцохыг хязгаарлаж, аж ахуйн шинжтэй чиг үүргүүдийг иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх бодлого баримтална.” гэж, 3.4.3.6-т “Барилга, барилгын материалын чанар, эрүүл ахуйн стандартыг олон улсын стандартын түвшинд нийцүүлж, чанарын хяналтыг мэргэжлийн холбоод, хөндлөнгийн хяналтын байгууллагаар хийлгэх тогтолцоонд шилжинэ.” гэж, 4.1.8-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх, оролцоог урамшуулж, хамтын ажиллагааны тодорхой арга, хэлбэрийг бэхжүүлж, үр дүнг дээшлүүлнэ.” гэж заажээ.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19.1-д Засгийн газар нь төрийн тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэхээр хуульчилсныг судалгааны эхний хэсэгт дурдсан билээ.

Энэ заалтын хэрэгжилтийг хангахын тулд Засгийн газрын 1995 оны 11 дүгээр тогтоолоор ***“Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх ерөнхий журам”***-ыг[37] баталсан. Энэ журмын нийтлэг үндэслэлд “...Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг холбогдох сайдын санал болгосноор Засгийн газар гаргана. Засгийн газрын бус байгууллага нь төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг гүйцэтгэхдээ хууль тогтоомж, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээг баримталж, холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Засгийн газрын бус байгууллагаас төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг эрхлэн гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заажээ.

Ийнхүү төрийн тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхэд захиргааны гэрээ байгуулахыг 2015 онд батлагдсан ***Захиргааны ерөнхий хуулийн*** [38] 52.2-т хуульчилсан. Тус хуулийн 8.1-д зааснаар захиргааны байгууллага нь хуулиар тусгайлан заасан бүрэн эрхээ гагцхүү хуулиар зөвшөөрсөн тохиолдолд л бусдад шилжүүлнэ. Ингэхдээ захиргааны байгууллага нь өөрийн зарим чиг үүрэг, эрх мэдлийг захиргааны гэрээгээр бусад этгээдэд шилжүүлэхийг 52.2.2-т хуульчилжээ.

---

[36] “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол. https://legalinfo.mn/mn/detail?lawId=6163

[37] “Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх ерөнхий журам”. Засгийн газрын 1995 оны 111 дүгээр тогтоолын хавсралт. https://legalinfo.mn/mn/detail?lawId=201046

[38] Захиргааны ерөнхий хууль. https://legalinfo.mn/mn/detail/11259

Төрийн тодорхой чиг үүргийг бусад байгууллагад гүйцэтгүүлэх боломжийг олгосон өөр суурь зохицуулалт нь ***Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль*** юм. Энэ хуулийн зорилт нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшил эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллах болон санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

2022 онд Засгийн газар “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоолыг Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор баталсан. Тогтоолын дагуу төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, төрийн зарим ажил, үйлчилгээг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлсэн.

Тухайлбал, Засгийн газрын 2022 оны 400 дугаар тогтоолоор “Төрийн ордны мэдээлэл, үйлчилгээний цогцолбор” (Төрийн ордны зоогийн газар, “Элит” төв, “Горхи” амралт), “Засгийн газрын хэвлэх үйлдвэр”-ийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгаж, Засгийн газрын 2022 оны 388 дугаар тогтоолоор “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрыг аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилсөн.

Мөн төрийн байгууллагууд хувийн хэвшил, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах арга хэмжээнүүдийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байдаг. Гэвч Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээнүүдийг хамтран хэрэгжүүлэх төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодыг хэт ерөнхий байдлаар оруулсан байдаг.

Дээр дурдсан хуулиудаас гадна Зөвшөөрлийн тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай болон бусад хуулиудаар Засгийн газрын гишүүд, яамдын төрийн нарийн бичгийн дарга нар, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурал, засаг дарга нар зэрэг хуулиар эрх олгосон эрх бүхий субъектүүд төрийн тодорхой чиг үүрэг, эрхийг бусдад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

(Төрийн тодорхой чиг үүргийг бусад байгууллагаар гүйцэтгүүлэхтэй холбоотой нийтлэг болон тухайлсан харилцааг зохицуулсан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоолын жагсаалт, холбогдох заалтыг Хавсралт 5.1-ээс дэлгэрүүлж үзнэ үү.)

(Төрийн байгууллага, албан тушаалтны зарим эрхийг бусдад шилжүүлэх буюу олгохтой холбоотой тухайлсан харилцааг зохицуулсан Монгол Улсын хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоолын жагсаалт, холбогдох заалтыг Хавсралт 5.2-оос дэлгэрүүлж үзнэ үү.)

Дөрөв. ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (ТӨБЗГ)-аас эмхэтгэн гаргасан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд” товхимолд[39] төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2011-2023 оны санхүү, эдийн засаг, үр ашгийн үзүүлэлтийг нэгтгэн танилцуулсан байна.

Уг товхимолд нийт 99 толгой ("Эрдэнэс Монгол" ХХК-ийн харьяа 20 охин, хараат компани, 3 төслийн нэгж, Эрчим хүчний яамны харьяа 7 охин, хараат компани, ТӨБЗГ-ын харьяа 2 охин, хараат компаниудыг оролцуулаад) компани, үйлдвэрийн газрыг хамруулсан байна. Үүнд:

- төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж ажилласан – 42;
- Эрчим хүчний яам – 27;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (“Эрдэнэс Монгол”) – 15;
- Сангийн яам – 7;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам – 1;
- Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам – 4;
- Зам, тээврийн хөгжлийн яам – 3.

(Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаарх мэдээллийг Хавсралт 5.3-аас үзнэ үү.)

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 64, 200.5 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 23, 617.9 тэрбум төгрөгийн орлого олж, 4, 983.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь 2022 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад орлого 66.3 хувиар буюу 9, 065.4 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 140.1 хувиар буюу 2, 908.1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

[39] Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд. ТӨБЗГ. 2024.

Зураг. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд



Эх сурвалж: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Хүснэгт. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2019-2023 оны санхүү, эдийн засгийн нэгдсэн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны гүйцэтгэл	2021 оны гүйцэтгэл	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл
	Хуулийн этгээдийн тоо /толгой компани/	тоо	107	107	105	98	99
1	Нийт орлого	мян.төг	9,693,551,633.57	9,789,318,194.26	10,648,974,489.29	14,552,590,929.62	23,617,950,239.24
2	Нийт зардал	мян.төг	7,507,109,745.10	9,266,485,758.86	9,147,787,131.91	11,541,278,971.39	16,911,652,100.02
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	2,186,441,888.47	522,832,435.40	1,501,187,355.92	3,011,311,958.23	6,706,298,139.22
4	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	1,594,012,359.03	204,130,633.39	1,034,881,569.64	2,075,081,884.45	4,983,187,645.04
5	Төсвийн төлбөрт	мян.төг	2,056,029,138.79	1,806,443,066.04	2,385,051,511.92	3,088,683,768.31	5,414,384,758.45
6	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	154,910,064.51	173,811,227.82	207,220,431.43	469,073,719.68	449,804,259.04
7	Нийт авлага	мян.төг	681,179,851.63	2,145,609,087.40	1,771,031,445.24	1,793,547,463.31	5,800,969,794.52
8	Нийт өглөг	мян.төг	4,154,469,379.16	16,365,214,739.88	18,126,711,036.97	21,277,071,923.98	22,791,853,610.42
8.1	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	1,541,921,993.87	4,607,336,561.26	5,138,281,421.70	7,951,144,843.51	12,497,148,545.88
8.2	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	2,612,547,385.29	11,757,878,178.63	12,988,429,615.81	13,325,927,080.47	10,294,705,064.54
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.77	0.95	0.86	0.79	0.72
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	797,719,880.59	4,734,777,491.90	4,099,845,345.74	1,275,123,013.27	863,462,831.33
11	Ажиллагсдын тоо	хүн	48,505	54,415	53,255	56,896	58,087
12	Цалингийн сан	мян.төг	39,743,774,136.51	44,159,749,040.57	1,278,750,564.39	1,543,899,820.70	2,157,835,397.32
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	мян.төг	3,882,689,743.39	7,443,878,699.97	7,141,703,396.55	9,505,216,950.45	17,606,304,129.73
14	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	мян.төг	28,543,797,552.58	43,727,964,248.94	46,340,147,661.88	49,731,961,655.37	46,594,239,173.68
15	Нийт хөрөнгө	мян.төг	32,426,487,295.97	51,171,842,948.91	53,481,851,058.45	59,237,178,605.82	64,200,543,303.41
16	Эздийн өмчийн дүн	мян.төг	28,272,017,916.81	34,806,628,209.03	35,355,140,020.73	37,960,106,681.60	41,408,689,692.97
17	Хөрөнгийн өгөөж	%	4.92	0.40	1.94	3.50	7.76
18	Эздийн өмчийн өгөөж	%	5.64	0.59	2.93	5.47	12.03

Эх сурвалж: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

(Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг Хавсралт 5.4-өөс үзнэ үү.)

Тав. ХАВСРАЛТУУД

5.1.Төрийн тодорхой чиг үүргийг бусад байгууллагаар гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан зарим хууль тогтоомж

5.1.1.НИЙТЛЭГ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

А) МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР		
№	***Хуулийн нэр, батлагдсан он***	***Хуулийн заалт***
1.	Захиргааны ерөнхий хууль, 2015	**5 дугаар зүйл.Захиргааны байгууллага** 5.1.Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно: 5.1.3.захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд; **52 дугаар зүйл.Захиргааны гэрээ** 52.2.Дараах харилцаанд захиргааны гэрээг хэрэглэж болно: 52.2.2.захиргааны байгууллага өөрийн зарим чиг үүрэг, эрх мэдлийг бусад этгээдэд шилжүүлэх харилцаанд;
2.	Зөвшөөрлийн тухай, 2022	**1.4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 1.2."зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд" /цаашид "эрх бүхий этгээд" гэх/ гэж хуулиар зөвшөөрөл олгох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан төрийн байгууллага, албан тушаалтан, эсхүл төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээдийг;
3.	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993	**19 дүгээр зүйл.Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх** 1.Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно. 2.Төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг биелүүлж, уг ажлаа Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцна.
4.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, 2022	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт** 1.1.Энэ хуулийн зорилт нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшил эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллах болон санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.
5.	Төрийн болон албаны нууцын тухай, 2016	**33 дугаар зүйл. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор төрийн болон албаны нууцыг шилжүүлэх** 33.1.Төрийн болон албаны нууцыг хариуцсан байгууллагын удирдлагын шийдвэрээр ажил гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээд, иргэнд зөвхөн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хэмжээ, хязгаарын дотор төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай нийтлэг журамд заасны дагуу шилжүүлж болно.
6.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 1996	**65[3] дугаар зүйл. Нийгмийн салбарын тусламж, үйлчилгээг гүйцэтгэлийн гэрээгээр гүйцэтгүүлэх** 1.Төрөөс нийгмийн салбарт үзүүлдэг тусламж, үйлчилгээг төрийн өмчийн оролцоогүй хуулийн этгээд, хувь хүнээр гүйцэтгэлийн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно
7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, 2023	**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.23."худалдан авах ажиллагаа" гэж бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагааг;

8.	Төрийн хэмнэлтийн тухай хууль, 2022	17.1.2.төр, олон нийтэд үзүүлж байгаа үйлчилгээний орлогоор өөрийгөө санхүүжүүлэх боломжтой төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газруудыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулах, тухайн чиг үүргийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх; 17.1.3.төрийн зарим нийтлэг үйлчилгээг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх;
9.	Төсвийн тухай хууль, 2011	**6 дугаар зүйл.Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх** 6.4.Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.3.иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг тэдгээрээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах; **39 дүгээр зүйл.Төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх** 39.1.Энэ хуулийн 14.1.6, 14.1.11-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчтай энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж болно. **61 дүгээр зүйл.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх** 61.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.2-т заасан төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэнэ.
Б) УИХ-ЫН ТОГТООЛООР		
№	***Тогтоолын нэр, батлагдсан он, дугаар***	***Тогтоолын заалт***
10.	УИХ-ын 2010 оны 48-р тогтоол, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	3.3.2.5.Төрөөс стратегийн ач холбогдолтой эдийн засгийн салбар дахь зайлшгүй үйл ажиллагаанаас бусад бизнест оролцохыг хязгаарлаж, аж ахуйн шинжтэй чиг үүргүүдийг иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх бодлого баримтална. 3.4.3.6.Барилга, барилгын материалын чанар, эрүүл ахуйн стандартыг олон улсын стандартын түвшинд нийцүүлж, чанарын хяналтыг мэргэжлийн холбоод, хөндлөнгийн хяналтын байгууллагаар хийлгэх тогтолцоонд шилжинэ.
11.	УИХ-ын 2020 оны 52-р тогтоол, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2.4.11.Тоон технологи ашиглан мэдээлэл, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд чиглэсэн инновацын үйл ажиллагааг төр, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ. 3.2.15.Орон сууцны төсөлд ухаалаг, байгалийн нөөцийн хэмнэлттэй, дэвшилтэт техник, технологи бүхий дэд бүтцийг улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаад, дотоодын зээл, тусламж, концессын гэрээгээр барьж байгуулах, нэвтрүүлэхийг банк, санхүүгийн тогтолцоогоор дэмжинэ. 3.5.11.Биеийн тамир, спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ. 5.2.14.Гэрээгээр гүйцэтгүүлж болох бүх төрийн чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудад шилжүүлэх тогтолцоог нэвтрүүлнэ. 5.4.3.Төрийн байгууллагын бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоож, төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар төрийн албан хаагчийн тоог бууруулна.
12.	УИХ-ын 2021 оны 106-р тогтоол, Шинэ сэргэлтийн бодлого	6.2.Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.

Б) ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛООР		
№	***Тогтоолын нэр, батлагдсан он, дугаар***	***Тогтоолын заалт***
13.	Засгийн газрын 1995 оны 111-р тогтоол, Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх ерөнхий журам	1.Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн зохицуулалт, мэдээлэл, шинжлэл судлалын зэрэг төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдон гарах зардлыг санхүүжүүлэхэд энэ журмыг баримтална. 2.Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг холбогдох сайдын санал болгосноор Засгийн газар гаргана. 3.Засгийн газрын бус байгууллага нь төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг гүйцэтгэхдээ хууль тогтоомж, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээг баримталж, холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 4.Засгийн газрын бус байгууллагаас төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг эрхлэн гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

5.1.2.ТУХАЙЛСАН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

А) МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР		
№	***Хуулийн нэр, батлагдсан он***	***Хуулийн заалт***
1.	Авто замын тухай, 2017	**13 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын оролцоо** 13.2.Энэ хуулийн 13.1-д заасан ажлыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх асуудлыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.
2.	Амьтны тухай, 2012	**21 дүгээр зүйл.Иргэн, нөхөрлөл, амьтан хамгаалах чиглэлийн мэргэжлийн болон төрийн бус байгууллагыг амьтны нөөцийг хамгаалахад оролцуулах** 21.6.Төрийн захиргааны төв байгууллага амьтныг хамгаалах талаарх төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу амьтны нөөцийг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.
3.	Ахмад настны тухай, 2017	**7 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ** 7.1.Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ дараахь төрөлтэй байна: 7.3.Энэ хуулийн 4.1.7, 4.1.8, 4.1.9, 4.1.11, 7.1-д заасан үйл ажиллагааны журмыг дараах байдлаар баталж, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ: 7.3.2.энэ хуулийн 7.1.6, 7.1.12-т заасан үйлчилгээг үзүүлэх эрхтэй, магадлан итгэмжлэгдсэн, эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан аж ахуй нэгж, байгууллагаар гүйцэтгүүлэх; 7.3.3.энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7, 7.1.8, 7.1.9, 7.1.10, 7.1.11-д заасан үйлчилгээг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага 7.3.1-д заасан журмын дагуу сонгон шалгаруулсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх. **15 дугаар зүйл. Ахмадын байгууллага** 15.3.Ахмад настны талаарх төрийн болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг болон энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг ахмадын байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардлыг гэрээний үндсэн дээр хэсэгчлэн, эсхүл бүрэн санхүүжүүлж болно.
4.	Ашигт малтмалын тухай, 2006	**10 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх** 10.1.Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.16.геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлах;

		39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 39.3.Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн биелүүлээгүй тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.9-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.
5.	Аялал жуулчлалын тухай, 2023	**16 дугаар зүйл.Аялал жуулчлалын бүс** 16.12.Аялал жуулчлалын бүсийн менежментийг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно. **17 дугаар зүйл.Отоглох цэг** 17.3.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт байрлах отоглох цэгийн менежментийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа хэрэгжүүлэх бөгөөд менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно. 17.4.Энэ хуулийн 17.1-д заасан улсын аялал жуулчлалын бүс нь улсын тусгай хамгаалалттай газартай давхцаагүй тохиолдолд тухайн аялал жуулчлалын бүс дэх отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.
6.	Байгалийн ургамлын тухай, 1995	**7 дугаар зүйл.Ургамлыг хамгаалах** 2.Нэн ховор, унаган буюу үлдвэр ургамлын удмын санг хамгаалах зорилгоор ургамлыг тарималжуулах, нутагшуулах ажлыг төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.
7.	Байгаль орчныг хамгаалах тухай, 1995	**32 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох** 2.Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаархи төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагад, эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан малчин өрхийн холбоо зэрэг этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.
8.	Барилгын тухай, 2016	**34 дүгээр зүйл. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг** 34.2.Энэ хуулийн 34.1.2, 34.1.3, 34.1.4, 34.1.6, 34.1.7, 34.1.8, 34.1.9, 34.1.10, 34.1.11, 34.1.13, 34.1.14, 34.1.15-д заасан чиг үүргийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно. **36 дугаар зүйл. Иргэн, төрийн бус байгууллагын оролцоо** 36.1.Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэ хуулийн 18.4, 34.2, 44.7-д заасны дагуу шилжүүлсэн чиг үүргийг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлж болно. **37 дугаар зүйл. Захиалагчийн чиг үүрэг** 37.2.Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно. **39 дүгээр зүйл. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт** 39.1.Барилга байгууламжийн зураг төсөлд хийх магадлалыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 34.1.10-т заасны дагуу эрх олгосон иргэн, хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ. **44 дүгээр зүйл. Барилгын салбарын ажилтан** 44.7.Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг гэрээний үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.
9.	Биеийн тамир, спортын тухай, 2024 Дагаж мөрдөх огноо: 2025-01-01	**10 дугаар зүйл.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх** 10.1.5.төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх спортын холбоог сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг батлах; **11 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг** 11.1.6.энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим чиглэлийг сэтгэл, оюуны болон бие бялдрын боловсролыг тэгш олгох чадамжтай төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлэх; **22 дугаар зүйл.Биеийн тамир, спортын магадлан итгэмжлэх үйл ажиллагаа**

		22.2.Биеийн тамир, спортын магадлан итгэмжлэлийг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон байгууллага гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг тайлагнана. **27 дугаар зүйл.Допингийн эсрэг үндэсний тогтолцоо** 27.2.Энэ хуулийн 27.1.3-т заасан байгууллага Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенц, Копенгагены тунхаглал, Дэлхийн болон допингийн эсрэг үндэсний дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ. (Допингийн эсрэг үндэсний байгууллага)
10.	Гаалийн тухай, 2008	**66 дугаар зүйл. Гаалийн зуучлагч** 66.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлтийг гэрээний үндсэн дээр гаалийн зуучлагчаар гүйцэтгүүлж болно. **252 дугаар зүйл. Гаалийн хяналт хийхэд шинжээч томилох** 252.4.Магадлан шинжилгээг мэргэжлийн хувийн өмчийн болон төрийн бус байгууллага, эсхүл бие даасан шинжээчээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд магадлан шинжилгээний төлбөрийг мэдүүлэгч хариуцна. **272[1] дүгээр зүйл. Төрийн бусад байгууллагатай хамтран ажиллах** 272[1].2.Гаалийн байгууллага нь гаалийн хяналт хийхээс бусад үүргийг холбогдох хуулийн дагуу төрийн бусад байгууллагаар гүйцэтгүүлж болно.
11.	Газрын тухай, 2002	**24 дүгээр зүйл.Газар зохион байгуулалт, түүний санхүүжилт** 24.2.Газар зохион байгуулалтын арга хэмжээг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.
12.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, 2016	**35 дугаар зүйл. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ** 35.6.Түр хамгаалах байрны ажуулгүй байдлын хамгаалалтыг цагдаагийн байгууллага, эсхүл гэрээт харуул хамгаалалтын байгууллагаар гүйцэтгүүлнэ.
13.	Далай ашиглах тухай, 2022	**5 дугаар зүйл.Далайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг** 5.1.4.гэрээний үндсэн дээр зарим чиг үүргийг төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлэх;
14.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, 2011	**19 дүгээр зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг** 19.1.5.төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах; 19.2.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хууль тогтоомж, бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, жендэрийн тэгш байдлын судалгаа, дүн шинжилгээний ажлыг жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно. **22 дугаар зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад олон нийтийн байгууллагын оролцоо** 22.2.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гэрээгээр хариуцан гүйцэтгэж болно.
15.	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай, 2019	**19 дүгээр зүйл.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх** 19.4.Хэрэгжилтийн тайланд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болох ба шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.
16.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, 2017	**20 дугаар зүйл.Залуучуудын хөгжлийг дэмжих төвийн чиг үүрэг** 20.3.Энэ хуулийн 20.2-т заасан чиг үүргийг магадлан итгэмжлэгдсэн залуучуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах залуучуудын иргэний нийгмийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.
17.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, 2015	**14 дүгээр зүйл.Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх** 14.5.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа тухайн мэргэжлийн сургалтыг удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагаар дараах ажил үүргийг гүйцэтгүүлж болно: 14.5.1.тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын стандарт, жолоодох эрхийн шалгалтын төвийн стандарт, сургалтын стандарт боловсруулах; 14.5.2.тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх, үйл ажиллагаанд нь үнэлгээ, дүгнэлт хийх;

		14.5.3.жолоодох эрхийн шалгалтын төвийн үйл ажиллагааг зохион байгуулах.
18.	Зар сурталчилгааны тухай, 2022	**24 дүгээр зүйл.Төрөөс зар сурталчилгаанд тавих хяналт** 25.3.Зар сурталчилгааны хяналттай холбоотой тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн улсын төсвөөс санхүүжүүлж болно.
19.	Зөвлөлдөх санал асуулгын тухай, 2017	**10 дугаар зүйл. Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах** 10.4.Статистикийн байгууллага энэ хуулийн 10.3-т заасан ажлыг хөндлөнгийн, бие даасан, хараат бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.
20.	Ирээдүйн өв сангийн тухай, 2016	**25 дугаар зүйл. Корпорацийн гүйцэтгэх удирдлага** 25.18.Гүйцэтгэх удирдлага Сангийн хөрөнгийн бүртгэл, хадгалалт, гүйлгээ болон бусад шаардлагатай үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр олон улсын нэр хүнд бүхий кастодианы байгууллагаар гүйцэтгүүлнэ. 25.19.Гүйцэтгэх удирдлага удирдах зөвлөлийн зөвшөөрөлтэйгээр Сангийн хөрөнгийн зарим хэсгийг гэрээний үндсэн дээр хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компаниар гүйцэтгүүлж болно.
21.	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай, 2024	**5 дугаар зүйл.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдал, үйл ажиллагаанд баримтлах зарчим** 5.1.Малчин өрхийн холбоо нь гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус хуулийн этгээд байна. Малчин өрхийн холбоо нь малчин өрхийн анхдагч холбоо, сумын, аймгийн, нэгдсэн холбооны зохион байгуулалттай байна. 5.2.Төрийн зарим чиг үүргийг малчин өрхийн холбоогоор хуульд заасны дагуу, эсхүл гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.
22.	Малчны тухай, 2024	**5 дугаар зүйл.Малчны эрх, үүрэг** 5.5.5.мал эмнэлгийн болон үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг мэргэжлийн нэгжээр гэрээний үндсэн дээр технологит хугацаанд гүйцэтгүүлэх;
23.	Малын генетик нөөцийн тухай, 2017	**14 дүгээр зүйл.Мал хамгаалах талаар малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээдийн үүрэг** 14.1.4.мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг технологийн зохистой хугацаанд энэ хуулийн 11.2-т заасан үйлчилгээний нэгжээр гүйцэтгүүлэх, үйлчилгээнд малаа бүрэн хамруулж, мал барьж туслах зэрэг шаардлагатай нөхцөлөөр хангах, үйл ажиллагааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх.
24.	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, 2021	**31 дүгээр зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах** 31.2.Нийслэл хотын удирдлага энэ хуулийн 8.2, 8.3-т заасан зарим чиг үүргээ холбогдох хуульд заасны дагуу гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болно.
25.	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай, 2024	**7 дугаар зүйл.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг** 7.1.4.хөгжлийн тэргүүлэх болон дэвшилтэт технологийн жагсаалтад багтсан чиглэлээр судалгаа шинжилгээний ажил, төсөл, хөтөлбөрийг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх; **10 дугаар зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэл** 10.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл санаачлах, хэрэгжүүлэхтэй холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу зохицуулна. 10.2.Төрийн байгууллага мэдээллийн технологийн үйлдвэрлэлтэй холбоотой дараах чиг үүргийг гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болно: 10.2.1.төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэхэд ашиглах дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, түүний засвар, арчлалт, үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах; 10.2.2.энэ хуулийн 8.1.4-т заасан бүх нийтийн цахим ур чадварын түвшнийг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах; 10.2.3.энэ хуулийн 8.1.5-д заасан мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх.
26.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, Үйлчилгээний тухай, 2024	**11 дүгээр зүйл.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт** 11.9.Энэ хуулийн 5.10.1, 5.10.2, 5.10.3, 5.10.4-т заасан тусламж, үйлчилгээг хувийн хэвшлийн, төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.
27.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, 2021	**32 дугаар зүйл.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг** 32.2.Энэ хуулийн 32.1.4, 32.1.13, 32.1.14, 32.1.15, 32.1.16, 32.1.18-д заасан чиг үүргийг бусад этгээдээр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгүүлж болно.

28.	Нотариатын тухай, 2011	**13 дугаар зүйл.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх** 13.2.Энэ хуулийн 13.1-д заасан бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг Танхимаар гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлж болно. (13.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн нотариатын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:…)
29.	Нягтлан бодох бүртгэлийн тухай, 2015	**17 дугаар зүйл.Нягтлан бодох бүртгэлийн удирдлагын тогтолцоо** 17.1.Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 17.1.8.нягтлан бодох бүртгэлийн зарим чиг үүргийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу гэрээгээр шилжүүлэн авсан төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;
30.	Ойн тухай, 2012	**18.2.Сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:** 18.2.8.ойн нөөцийн бүртгэл, ой зохион байгуулалтын ажлыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, сумын ойн менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх; **18.2.Сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:** 18.2.8.ойн нөөцийн бүртгэл, ой зохион байгуулалтын ажлыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, сумын ойн менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх;
31.	Олон нийтийн радио, телевизийн тухай, 2005	**31 дүгээр зүйл.Олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирал, түүний бүрэн эрх** 31.7.Хяналтын зөвлөлийн зөвшөөрлийг үндэслэн Ерөнхий захирал олон нийтийн радио, телевизийн зарим ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.
32.	Олон улсын гэрээний тухай, 2016	**7 дугаар зүйл. Олон улсын гэрээ үйлдэх хэл, орчуулга** 7.8.олон улсын гэрээний орчуулгыг иргэн, хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. **25 дугаар зүйл. Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан** 25.8.олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан, зөвлөмжийн орчуулгыг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.
33.	Органик бүтээгдэхүүний тухай, 2024	**7.2.Органик үйлдвэрлэл эрхлэгч дараах үүрэг хүлээнэ:** ы7.2.12.ойн дагалт баялаг болон байгалийн ургамлыг түүх ажлыг бусдаар гүйцэтгүүлэх бол холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, зааварчилгаа өгч, тэмдэглэл хөтлөх.
34.	Орон нутгийн хамгаалалтын тухай, 2018	**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 4.1.7."томилгоожуулах" гэж иргэн, хуулийн этгээдийг орон нутгийн хамгаалалтын үүрэг гүйцэтгүүлэхээр томилохыг.
35.	Орон сууцны тухай, 1999	**14 дүгээр зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн засвар, үйлчилгээ** 14.2.Энэ хуулийн 14.1-д заасан засвар, үйлчилгээ, тохижилтын ажлыг сууц өмчлөгч өөрөө хийж, эсхүл эрх бүхий мэргэжлийн байгууллага буюу хувь хүнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.
36.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай, 2024	**11 дүгээр зүйл.Судалгаа, хөгжүүлэлтийн дэмжлэг** 11.1.Төрөөс соёлын бүтээлч үйлдвэрлэлийн судалгаа, хөгжүүлэлтэд дараах хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ: 11.1.5.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бодлого, статистик, инновац, оюуны өмчийн үнэлгээ, технологийн судалгаа, хөгжүүлэлтийн суурь болон хавсарга судалгааг гэрээний үндсэн дээр дээд боловсролын сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх.
37.	Соёлын тухай, 2021	**26 дугаар зүйл.Соёлын салбарын түншлэл** 26.4.Соёлын салбарын зарим ажил, үйлчилгээг мэргэжлийн төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд уг байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт болон холбогдох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
38.	Сонгуулийн төв байгууллагын тухай, 2006	**12 дугаар зүйл. Хорооны ажлын зохион байгуулалт** 12.7.Хороо хуваарилагдсан төсвийн хөрөнгийн хэмжээнд сонгуулийг бэлтгэн явуулахтай холбоотой ажил гүйцэтгүүлэх зорилгоор хувь хүн, хуулийн этгээдтэй иргэний эрх зүйн гэрээ байгуулан ажиллаж болно.
39.	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний	**25 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага** 25.3.7.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр шинжлэх ухаан, технологийн судалгаа, шинжилгээ хийх, энэ хуулийн 25.3.6-д

	итгэмжлэлийн тухай, 2017	заасан ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;
40.	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай, 2003	**5 дугаар зүйл.Сууц өмчлөгчдийн холбоо** 5.8.Холбоо нь дундын өмчлөлийн эд хөрөнгө, шугам сүлжээний засвар, үйлчилгээг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд засвар, үйлчилгээ хийлгэх мэргэжлийн байгууллагаа чөлөөтэй сонгох эрхтэй.
41.	Таримал ургамлын үр, сортын тухай, 2021	**14 дүгээр зүйл.Сортын бүтээгчийн эрх олгох** **1**4.5.Сортыг шинэ, ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоохдоо энэ хуулийн 14.1-д заасан байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 14.5.3.энэ хуулийн 14.5.2-т заасан туршилтыг дараах этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлнэ: 14.5.3.а.тухайн сортын бүтээгчээр; 14.5.3.б.бусад хуулийн этгээдээр; 14.5.3.в.Монгол Улсын олон улсын гэрээний гишүүн орны эрх бүхий байгууллагаар; 14.5.3.г.энэ хуулийн 14.5.3.а-14.5.3.в-д заасан этгээд хамтран.
42.	Төрийн албаны тухай, 2017	**33 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албаны шалгалт** 33.11.Төрийн албаны төв байгууллага энэ хуулийн 33.7 (Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.)-д заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж болно.
43.	Төрийн аудитын тухай, 2020	**8 дугаар зүйл.Санхүүгийн тайлангийн аудит** 8.4.Төрийн аудитын байгууллага энэ хуульд заасан санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.
44.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, 2023	49.5.Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 49.4.5, 49.4.8, 49.4.10-т заасан чиг үүргийг мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. 49.9.Гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг тухайн байгууллагын хүсэлтэд үндэслэн худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.
45.	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай, 2013	**16 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах** 16.2.Энэ хуулийн 16.1-д зааснаас бусад хуулийн этгээд нь тэсэлгээний ажлыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.
46.	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалллын тухай, 2024	**18 дугаар зүйл.Ургамал хамгаалллын бүтээгдэхүүн** 18.4.Тариалангийн талбай, хүлэмж, зоорь, агуулах, бэлчээр, ойд хөнөөлт организмтай тэмцэхдээ химийн болон цацрагийн аргыг сонгосон тохиолдолд пестицидтэй ажиллах талаарх сургалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.
47.	Усны тухай, 2012	**21 дүгээр зүйл.Усны мэргэжлийн байгууллага** 21.7.Усны мэргэшсэн хүний нөөцийн сургалтыг сонгон шалгаруулалт явуулж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, гидрологи, гидрогеологич, гидротехникч инженерд мэргэшсэн зэрэг олгоно.
48.	Харилцаа холбооны тухай, 2001	**8 дугаар зүйл.Харилцаа холбооны зохицуулах хороо** 8.13.Зохицуулах хороо нь хуульд заасан зарим чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлж болно.
49.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 2016	**7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх** 7.3.Энэ хуулийн 7.1.4-т заасан арга хэмжээг зохион байгуулах ажлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалдаг байгууллагатай гэрээгээр гүйцэтгүүлж болох ба холбогдох зардлыг Нийгмийн халамжийн сангаас гаргана.
50.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, 2011	**10 дугаар зүйл.Хөдөлмөрт бэлтгэх** 10.2.Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний үйлчилгээ, дэмжлэг, туслалцааг хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

51.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, 2008	**27 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц, зохион байгуулалт** 27.7.Энэ хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.6-д заасан этгээд, аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан ажиллуулах орон тоонд хүрээгүй тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг мэргэшсэн байгууллага, ажилтнаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.
52.	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай, 2011	**6 дугаар зүйл.Биржийн төлбөр тооцоо, хадгаламж** 6.1.Бирж нь биржийн гэрээний төлбөрийн үүргийг тодорхойлох, төлбөр тооцоог гүйцэтгэх, гэрээг бүртгэх, хадгалах үйлчилгээг гэрээний үндсэн дээр банк, үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагаар гүйцэтгүүлэх, эсхүл уг үүргийг гүйцэтгэх тусгайлсан нэгж /цаашид "төлбөр тооцооны төв" гэх/-тэй байна.
53.	Хөрөнгийн үнэлгээний тухай, 2022	**5 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийх үндэслэл** 5.2.Нийтийн эрх ашгийг хөндсөн дараах хөрөнгийн үнэлгээг үнэлгээний хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ: 5.2.1.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.2-т заасан аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн үнэлгээний зүйлийг санхүүгийн тайлагналын зорилгоор үнэлэхэд; 5.2.2.төрийн болон орон нутгийн өмчийг хувьчлах, үл хөдлөх эд хөрөнгийг худалдах, зээлийн барьцаанд ашиглах, өр төлбөрт тооцоход; 5.2.3.төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийг өөрчлөхөд; 5.2.4.ашигт малтмалын болон газрын тосны орд, байгалийн хийн хөрөнгө болон байгалийн бусад баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулахад; 5.2.5.хөрөнгийн үнэлгээний зүйлийг төрийн болон орон нутгийн хэрэгцээнд буцаан авахад; 5.2.6.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцааг нийтэд санал болгон гаргах үед; 5.2.7.тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх тохиолдолд.
54.	Хөрөнгө оруулалтын сангийн тухай, 2013	**39 дүгээр зүйл.Нягтлан бодох бүртгэл хөтлөх** 39.2.Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийг хөрөнгө оруулалтын менежментийн компани гүйцэтгэх бөгөөд тус компани нь бүртгэлийг Хороонд бүртгүүлсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрх авсан мэргэшсэн нягтлан бодогчоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.
55.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай, 2012	**5 дугаар зүйл.Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх** 5.1.Хүн худалдаалахтай тэмцэх талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.3.хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх.
56.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, 2003	**16 дугаар зүйл.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх** /16 дугаар зүйлийн гарчигт 2008.12.19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/ 16.1.3.хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон асуудлаар хууль тогтоомжийн биелэлтийг шалгах, холбогдох байгууллагатай хамтран үзлэг шалгалт явуулах, мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, тэдэнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх. /Энэ заалтад 2008.12.19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/
57.	Цахим гарын үсгийн тухай, 2021	**21 дүгээр зүйл.Гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой бүртгэл хийх** 21.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний үндсэн дээр бусад этгээдээр энэ хуулийн 21.2-т заасан үүргийг гүйцэтгүүлж болно.
58.	Шинэ зуунмод хотын эрх зүйн байдлын тухай, 2024	**12 дугаар зүйл.Хотын удирдлага, түүний тогтолцоо** 12.7.Хотын удирдлага энэ хуульд заасан зарим чиг үүргээ холбогдох хуульд заасны дагуу гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болно.
59.	Шуудангийн тухай, 2003	**16 дугаар зүйл.Үйлчлэгчийн эрх, үүрэг** 16.1.4.шаардлагатай гэж үзвэл шуудангийн зарим үйлчилгээг гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлэх асуудлыг шийдвэрлэж, биелэлтэд нь хяналт тавих;
60.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, 2024	**20 дугаар зүйл.Эмийг зах зээлд гаргасны дараах тандалт судалгаа** 20.13.Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шаардлагатай тохиолдолд тандалт судалгаа гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээгээр гүйцэтгүүлж болно.

		40 дүгээр зүйл.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа 40.2.Баталгаат хугацаа дууссан эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, засвар тохируулгыг тухайн эрүүл мэндийн байгууллага хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд гэрээгээр гүйцэтгүүлж болно. **50 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх** 50.1.24.зарим чиг үүргээ төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх; **54 дүгээр зүйл.Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын оролцоо** 54.1.1.төрийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;
61.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, 2016	**21 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн зохицуулалт** 21.8.Хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх энэ хуулийн 18.1-д заасан тусламж, үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
62.	Эрүүл ахуйн тухай, 2016	**13 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг** 13.1.10.50 ба түүнээс доош ажилтантай үйлдвэр, үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгж нь энэ хуулийн 13.1.9-т заасан ажилтныг гэрээгээр гүйцэтгүүлж болох;
63.	Эрүүл мэндийн тухай, 2011	**16 дугаар зүйл.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын чиг үүрэг** 16.2.Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна. **45 дугаар зүйл.Эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд төрийн бус байгууллагын оролцоо** 45.3.Эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам, төрийн бус байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
64.	Эрчим хүч хэмнэлтийн тухай, 2015	**9 дүгээр зүйл. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрх** 9.2.Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь энэ хуулийн 9.1.7, 9.1.8-д заасан бүрэн эрхийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.
65.	Эрчим хүчний тухай, 2001	**17 дугаар зүйл.Эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл** 17.3.Эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэр дээрх зарим хэрэглэгчдийн цахилгаан, дулааны борлуулалтыг иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Гэрээт борлуулагчид худалдах үнэ, төлөх шимтгэлийг хоорондын гэрээгээр тохиролцох ба хэрэглэгчид Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон үнээр худалдана.
Б) ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛООР		
№	***Тогтоолын нэр, батлагдсан он, дугаар***	***Тогтоолын заалт***
1.	Монголын өмгөөлөгчдийн байгууллагаар эрх зүйн сургалт зохион байгуулах, хууль тогтоомж сурталчлах зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх тухай, 1996, №117	Эрх зүйн сургалт зохион байгуулах, хууль тогтоомж сурталчлах чиг үүргийн зарим хэсгийг туршилтын журмаар Монголын өмгөөлөгчдийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх тухай Хууль зүйн сайд Н.Лувсанжавын саналыг зөвшөөрсүгэй.
2.	Стандартчилал, хэмжилзүйн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагаар	Стандартчилал, хэмжилзүйн чиглэлээр сургалт явуулах, мэдээлэл арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөлгөө өгөх чиг үүргийг гэрээний үндсэн дээр төрөөс нэмэгдэл зардал гаргахгүйгээр Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

	гүйцэтгүүлэх тухай, 1999, №121	
3.	Гэгээрлийн салбарын зарим байгууллагын менежментийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай, 2000, №90	1.Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль, Хүнсний технологийн сургууль, "Монгол кино нэгтгэл" улсын үйлдвэрийн газрын менежментийг гэрээгээр гүйцэтгүүлэх туршилтад хамруулахыг Гэгээрлийн сайд А.Баттөрд зөвшөөрсүгэй.
4.	Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тухай, 2008, №93	Засгийн газраас Иргэний нийгмийн зөвлөлтэй хамтран ажиллах гэрээг зарчмын хувьд дэмжиж, түүнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболдод олгосугай.
5.	Нягтлан бодох бүртгэл, хяналтын чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай, 2008, №237	Нягтлан бодох бүртгэл, хяналтын зарим чиг үүргийг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж уг ажилд шаардагдах 38.0 (гучин найман) сая төгрөгийг жил бүр төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.
6.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай, 2014, №49	1.Хустайн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үүргийг "Хустай цогцолборт газар" төвөөр гэрээний үндсэн дээр 10 жилийн хугацаагаар гүйцэтгүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд зөвшөөрсүгэй.
7.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай, 2014, №250	1.Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг барилгын салбарын төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд зөвшөөрсүгэй.
8.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай, 2014, №251	1.~~Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх,~~ хот байгуулалтын баримт бичигт экспертизийн дүгнэлт гаргах иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, тэдгээрийг зохион байгуулах чиг үүргийг хариуцлага хүлээх чадвар бүхий мэргэжлийн хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд зөвшөөрсүгэй. /Энэ заалтад Засгийн газрын 2018 оны №51 тогтоолоор өөрчлөлт орсон/
9.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай, 2016, №124	1.Төрөөс ахмад настны талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ахмад настныг нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах, хөдөлмөр эрхлэх боломж бий болгох, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгэмд насжилтын талаар эерэг хандлага, зан байдлыг бий болгох талаарх Засгийн газрын бодлого, шийдвэрийг сурталчлах, ахмад настны бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, улсын хэмжээнд ахмад настны аж байдлыг тогтмол судалж дүгнэлт, санал гаргах, ахмад настан бүрт хүрч ажиллан тэдний санал, сэтгэгдлийг сонсох, ядуу амьдралтай ахмадуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг төрийн гүйцэтгэх зарим чиг үүргийг Монголын ахмадын холбоогоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэн хамтарч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд Н.Номтойбаярт зөвшөөрсүгэй.
10.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай, 2016, №165	1.Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулиудад заасан дараах төрийн зарим чиг үүргийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэхийг зөвшөөрч, холбогдох гэрээнд гарын үсэг зурах эрхийг Сангийн сайд Б.Болорт олгосугай

11.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, 2016, №234	Монголын улаан загалмай нийгэмлэгээр Засгийн газар, нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах
12.	Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай, 2018, №51	1.Барилгын тухай хуулийн 34.1.2, 34.1.4, 34.1.6, 34.1.7, 34.1.8, 34.1.9, 34.1.10, 34.1.11, 34.1.13, 34.1.15-д заасан барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг "Барилгын хөгжлийн төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газраар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд зөвшөөрсүгэй.
13.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай, 2018, №216	1. Барааг түр хугацаагаар оруулах тухай конвенцын "Тээврийн хэрэгслийн тухай хавсралт С"-д заасан тээврийн хэрэгслийг гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлэх таслах хуудас бүхий дагалдах дэвтэр (CPD карней)-ийг олгох, Монгол Улсын нутаг дэвсгэрт уг дэвтэрт тэмдэглэгдсэн асуудалтай холбогдон үүсэх хариуцлагыг хүлээх, баталгаа гаргах чиг үүргийг Монголын автомашин, мотоциклын спортын холбоогоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.
14.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай, 2020, №60	1.Төрөөс эмэгтэйчүүдийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, охид, эмэгтэйчүүдийг хөгжүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх, тэднийг бүх төрлийн жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, энэ чиглэлээр нийгмийг соён гэгээрүүлэхэд Засгийн газрын бодлого, шийдвэрийг сурталчлах, таниулах, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулахад нийгмийн бүх бүлгийн эмэгтэйчүүдэд хүрч ажиллах чиглэлээр төрийн гүйцэтгэх зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр Монголын эмэгтэйчүүдийн холбоотой хамтарч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд С.Чинзоригт, аймаг, нийслэл, сум, дүүргийн Монголын эмэгтэйчүүдийн холбооны салбар зөвлөлтэй хамтран ажиллахыг холбогдох Засаг дарга нарт тус тус зөвшөөрсүгэй.

---o0o---

5.2.Төрийн байгууллага, албан тушаалтны зарим эрхийг бусдад шилжүүлэх буюу олгохтой холбоотой харилцааг зохицуулсан зарим хууль тогтоомж

5.2.1.НИЙТЛЭГ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

А) МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР		
№	***Хуулийн нэр, батлагдсан он***	***Хуулийн заалт***
1.	Захиргааны ерөнхий хууль, 2015	**6 дугаар зүйл.Захиргааны байгууллагыг төлөөлөх** 6.1.Захиргааны байгууллагыг хуулиар бүрэн эрх олгогдсон удирдах албан тушаалтан хуульд заасны дагуу итгэмжлэлгүйгээр, эсхүл хуулиар эрх олгогдсон удирдах албан тушаалтны шийдвэрээр итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлнө. **8 дугаар зүйл.Захиргааны байгууллагын эрх шилжүүлэх** 8.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно. **52 дугаар зүйл.Захиргааны гэрээ** 52.2.Дараах харилцаанд захиргааны гэрээг хэрэглэж болно: 52.2.2.захиргааны байгууллага өөрийн зарим чиг үүрэг, эрх мэдлийг бусад этгээдэд шилжүүлэх харилцаанд; **59 дүгээр зүйл.Захиргааны хэм хэмжээний акт** 59.2.Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд захиргааны хэм хэмжээний акт гаргах эрхээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно. **95 дугаар зүйл.Гомдлыг хянан шийдвэрлэх журам** 95.9.Гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллага гомдлыг шийдвэрлүүлэхээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
2.	Зөвшөөрлийн тухай, 2022	**1.4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 1.2."зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд" /цаашид "эрх бүхий этгээд" гэх/ гэж хуулиар зөвшөөрөл олгох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан төрийн байгууллага, албан тушаалтан, эсхүл төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээдийг; **1.5 дугаар зүйл.Зөвшөөрөл олгох, сунгах, шинээр бий болгоход баримтлах зарчим, хэрэгжүүлэх хүрээ** 4.Төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон, эрх шилжүүлсэн бол хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болох бөгөөд үүсэх үр дагаврыг зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон, эрх шилжүүлсэн этгээд хариуцна.

5.2.2.ТУСГАЙЛСАН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

А) МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР		
№	***Хуулийн нэр, батлагдсан он***	***Хуулийн заалт***
1.	Байгаль орчныг хамгаалах тухай, 1995	**7 дугаар зүйл.Байгаль орчны үнэлгээ** 4.Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ олгоно. /Энэ хэсэгт 2023.01.06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./ /Энэ хэсэгт 1998.01.22-ны өдрийн хуулиар нэмэлт, 2012.05.17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/ 5.Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх олгоно:
2.	Барилгын тухай, 2016	**34 дүгээр зүйл. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг** 34.1.10.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;

3.	Боловсролын ерөнхий хууль, 2023	**20 дугаар зүйл.Зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг, түүнд тавих шаардлага** 20.2.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхээ Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагад шилжүүлж болно.
4.	Валютын зохицуулалтын тухай, 1994	**12 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гадаад валютын гүйлгээ** 1.Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2, 3 мөн зүйлийн 8 дахь хэсэгт заасан байнга буюу түр оршин суугчид нь гадаад валютыг худалдах, худалдан авах болон зээлдэх, шилжүүлэх ажиллагааг зөвхөн Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэнэ.
5.	Генетик нөөцийн тухай хууль, 2021	**12 дугаар зүйл.Генийн сан** 12.1.Генийн санд хамрагдах генетик материалын биет сан хөмрөг, түүний тоон өгөгдлийн санг тухайн чиглэлийн суурь судалгаа хийх үүрэг бүхий байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага төрөлжүүлсэн байдлаар эрхэлж болно.
6.	Зохиогчийн эрхийн тухай, 2021	**41 дүгээр зүйл.Хараагүй, сонсголгүй, харааны, эсхүл сонсголын бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан ашиглах** 41.3.Хараагүй, сонсголгүй, харааны, эсхүл сонсголын бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүнийг боловсрол, мэргэшсэн сургалт, номын сан, мэдээллээр хангах чиглэлээр, дагнасан үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон Засгийн газраас эрх олгосон ашгийн төлөө бус байгууллага /цаашид "эрх бүхий байгууллага" гэх/ ажиллана.
7.	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, 2002	**17 дугаар зүйл.Иргэнд өмчлүүлэх газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа** 17.2.Иргэнд өмчлүүлэх газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага газрын тухай хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэж дүгнэлт гаргана.
8.	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, 2017	**19 дүгээр зүйл.Итгэмжлэлийн байгууллага** 19.3.Итгэмжлэлийн байгууллага итгэмжлэлийн бодлогыг хэрэгжүүлэх бөгөөд дараахь бүрэн эрхтэй: 19.3.2.итгэмжлэлийн шинжээчид тавих шаардлагыг тогтоох, шинжээч сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох, цуцлах;

---o0o---

5.3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн байгуулагдсан талаарх мэдээлэл лавлагаа

Эх сурвалж: *“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд”. ТӨБЗГ. 2024 он.*

№	Хуулийн этгээдийн нэр	Төрөл	Байгуу-лагдсан он	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч	Төрийн эзэмш-лийн хувь	Шийдвэр
1.	"Улаанбаатар төмөр зам" ХНН	Монгол-Оросын Хувь нийлүүлсэн нийгэмлэг	1949	Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд ОХУ-ын “РЖД” НХН-ийн ерөнхий захирал	50%	1949 онд “Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг байгуулах тухай Засгийн Газар хоорондын хэлэлцээр”-т БНМАУ-ын талыг төлөөлж Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан, ЗСБНХУ-ын талыг төлөөлж Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ю.К Приходов нар гарын үсэг зурсан.
2.	"Эрдэнэс тавантолгой" ХК	Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани	2010	“Эрдэнэс Монгол” ХХК	73.51%	УИХ-ын 2010 оны "Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай" 39-р тогтоол, Засгийн газрын 2010 оны 272-р тогтоолоор байгуулсан.
3.	"Монголын хөрөнгийн бирж” ХК	Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани	1991	Сангийн яам	66%	Засгийн газрын 1991 оны 22-р тогтоолоор байгуулсан.
4.	"Төрийн банк" ХК	Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани	2009	Сангийн яам	94.29%	Засгийн Газрын 2009 оны 348-р тогтоол, Сангийн сайдын 2009 оны 259-р тушаалын дагуу 100 хувь төрийн өмчит “Төрийн банк”-ийг үүсгэн байгуулахаар шийдвэрлэж, Банкны тухай хуулийн 18.2, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375-р тушаалаар батлагдсан “Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ыг үндэслэн 2009 оны 11-р сарын 23-ны өдөр байгуулсан.
5.	"Монголын цахилгаан холбоо" ХК	Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани	1921	ТӨБЗГ	94.7%	1995 оноос "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн нийт хувьцааны 54.7%-ийг Монгол Улсын Засгийн газар, 40.0%-ийг БНСУ-ын Кореа Телеком корпораци, 5.3%-ийг Монгол Улсын болон гадаадын иргэд, хуулийн этгээд эзэмшиж байсан. 2018.04.19-ний өдөр Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Кореа телеком корпораци хооронд байгуулсан гэрээний дагуу компанийн нийт хувьцааны 40%-ийг худалдах арилжаагаар Монгол Улсын Засгийн Газар тус компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа худалдан авсан.
6.	"Монгол шуудан" ХК	Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани	1921	ТӨБЗГ	66%	2016 онд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан компанийн нийт хувьцааны 34%-ийг олон нийтэд хувьчилснаар нээлттэй хувьцаат компани болсон.
7.	"Дулааны II цахилгаан станц" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1961	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2001 оны 164-р тогтоолоор төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулсан.
8.	"Дулааны III цахилгаан станц" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1968	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2001 оны 164-р тогтоолоор төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулсан.
9.	"Дулааны IV цахилгаан станц" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1983	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2001 оны 164-р тогтоолоор төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулсан.
10.	"Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1965	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2001 оны 164-р тогтоолоор төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулсан.

№	Хуулийн этгээдийн нэр	Төрөл	Байгуу-лагдсан он	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч	Төрийн эзэмш-лийн хувь	Шийдвэр
11.	"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1987	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2001 оны 164-р тогтоолоор төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулсан.
12.	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1932	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2021 оны 164-р тогтоолоор ТӨХК болгон өөрчилсөн.
13.	"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1959	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2021 оны 164-р тогтоолоор ТӨХК болгон өөрчилсөн.
14.	"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1988	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2001 оны 164-р тогтоолоор ТӨХК-ийг байгуулсан.
15.	"Дарханы дулааны сүлжээ" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1965	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2021 оны 164-р тогтоолоор ТӨХК болгон өөрчилсөн.
16.	"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1973	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн Газрын 2001 оны 164-р тогтоолоор ТӨХК-ийг байгуулсан.
17.	"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1970	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2021 оны 164-р тогтоолоор ТӨХК болгон өөрчилсөн.
18.	"Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	2001	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2001 оны 164-р тогтоолоор төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулсан.
19.	"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	1984	Эрчим хүчний яам – 66% ТӨБЗГ – 34%	100%	Засгийн газрын 2021 оны 164-р тогтоолоор ТӨХК болгон өөрчилсөн.
